# ХОВД АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2024 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

**2024.12.03**

## *НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БУСАД АЖЛЫН ТАЛААР*

Тус *УЦУОШТөв нь* 2024 онд Ховд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Цаг уур Орчны технологийн хэлтэс, Захиргаа, санхүү аж ахуйн хэлтэс, Мэдээлэл үйлчилгээний хэлтэс гэсэн үндсэн бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Орон нутагт Цаг уурын өртөө 9, ХАА-н цаг уурын харуул 7, ус судлалын харуул 10, нуур судлалын харуул 1, Цацрагийн түвшний ажиглалтын цэг 2, Цэвдэг судлалын цэг 2, УМСалбар, Цаг уурын салбар, ХАА-н цаг уурын салбар, Ус судлалын салбар, Мөстөл судлалын салбар, Холбоо сүлжээ, Байгаль орчны шинжилгээний лаборатори, Архив мэдээллийн дэд сан, Цаг агаарт зориудаар нөлөөлөх явуулын 2 экспедиц зэрэг салбар нэгжид үндсэн 96 хүний орон тоотой **1051602200** төгрөгний санхүүжилтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 4 зорилт 77 төрлийн үйл ажиллагаа хийхээр төлөвлөгөөнд тусгаж ЦУОШГазрын даргаар батлуулан ажилдаа мөрдлөг болгон ажиллалаа. 2024 онд хийхээр төлөвлөж төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлт 99.15 хувьтай хийж гүйцэтгэлээ.

Тус төв нь харъяа салбаруудын ажилд цаг уур орчны хяналт шинжилгээний тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай, Монгол улсын бусад хуулиудыг хэрэгжүүлэх, Ус цаг уурын улсын сүлжээний өртөө, харуулуудын шинжилгээний хөтөлбөрт ажлыг хангаан биелүүлэх, ажлын тасралтгүй ажиллагааны нөхцлийг бүрдүүлэх, шинжилгээ мэдээлэл үйлчилгээний ажлын технологийн мөрдөлтийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулсан.

Оны эхэнд 2023 онд хийсэн ажлынхаа гүйцэтгэлийн тайлангийн биелэлт, байгууллагын 2024 онд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ЦУОШГазрын даргаар баталгаажуулан ажиллалаа. Байгууллагын удирдлага төвийн ажилтантай хөдөлмөрийн гэрээгээр хийх ажлын төлөвлөгөөг 95 ажиллагсадтай хийж баталгаажуулан ажилласан.

**УЦУОШТөв нь 2024 онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан**

1. Бүх төрлийн шинжилгээний хөтөлбөрт ажлын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангуулах
2. Байгалийн учирч болзошгүй гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цаг агаарын аюулт үзэгдлийг эрт зарлан мэдээлэх
3. Орон нутагт ажиллаж байгаа салбар нэгжүүд сум орон нутагтайгаа нягт хамтран ажиллаж сум хөгжүүлэх сангийн зардлаас тодорхой санхүү төсөв шийдүүлж ажиллах
4. ЦАЗН үйл ажиллагааны үр дүнг оновчтой тооцож, нэмэгдүүлэх

**УЦУОШТ-ийн 2024 онд хийж хэрэгжүүлэх зорилтуудын биелэлт:**

**1-р зорилтын хүрээнд:** Бүх төрлийн шинжилгээний хөтөлбөрт ажлын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс цаг уурын автомат станцуудад гарсан гэмтэл саатлыг тухай бүрэн нь арилгах, мэдээний тасалдал гаргахгүй ажиллах үүднээс орон нутгийн салбар нэгжүүдтэй технологийн дэвшил интернэт сүлжээг үйл ажиллагаандаа өргөн ашиглаж Anydesk Ultraviewer программаар орон нутагтай цаг алдалгүй холбогдож автомат станцын тасралтгүй ажиллагааг хангаан ажиллаж байна.

Орон нутгийн цаг уурын өртөө, харуул, ус судлалын шинжилгээний хөтөлбөрт ажиглалтын технологи мөрдүүлэх, өртөө харуулуудад гарч байгаа алдаагаа дутагдалыг засаж залруулах, зөвлөмж зааварчилгаа газар дээр нь өгөх үүднээс бүх салбартаа шалгах туслах ажлыг хийснээр шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын чанарт сайнаар нөлөөлсөн. 2024 онд ямар нэгэн шалтгааны улмаас шинжилгээний хөтөлбөрт ажиглалт тасраагүй бүрэн хийгдсэн.

**2-р зорилтын хүрээнд:** Байгалийн учирч болзошгүй гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цаг агаарын аюулт үзэгдлийг эрт зарлан мэдээлэх ажлыг энэ онд

хүчтэй салхиар 5 удаа, шороон шуургаар 1 удаа, цочир хүйтрэлтээр 4 удаа, хоногийн 5 удаа нарийвчилсан, сэрэмжлүүлэх мэдээг хоногоор их цасаар 1 удаа, хүчтэй салхиар 1 удаа, нарийвчилсан 1 удаа, анхааруулга мэдээг 57 удаа тус тус гаргаж khovd.tsag-agaar.gov.mn болон alarm.tsag-agaar.gov.mn цахим хуудас, Ховд Ус, цаг уур орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудас, LED дэлгэцээр гэх мэт цахим сүлжээгээр хэрэглэгчдэд хүргэж мэдээний чанар 95.1 хувь, онч 95.8 хувьтай зорилтот түвшнээс таарцыг 5.1 хувиар ахиулж, оньч 4.2 хувиар буурсан үзүүлэлттэй ажилласан.







*Зураг. СМ, УСМ-г пэйж хуудас, цахим хуудсанд байршуулсан байгаа нь.*

**3-р зорилтын хүрээнд:** Орон нутагт ажиллаж байгаа салбар нэгжүүд сум орон нутагтайгаа нягт хамтран ажиллаж сум хөгжүүлэх сангийн зардлаас тодорхой санхүү төсөв шийдүүлж ажиллаж, ажилчдын тав тухтай ажиллах нөхцөл бүрдүүлэх үүднээс сум орон нутгийн хөгжлийн сангаас салбар нэгжүүд нийт 53.5 сая төгрөгний санхүү шийдүүлж, ажилчдын ажиллах тав тухтай орчин бүрдүүлэх, өрөө байрны тохижилтонд зориулж бараа материал худалдан авах, шинжилгээний хөтөлбөрт ажил хийхэд шаардлагатай багаж төхөөрөмж авч ажиллсан. Төвийн халаалтыг аймгийн төвийн төвлөрсөн дулаанд холбосон. /85 сая төгрөгөөр холболтын ажил хийлгэсэн/

**4-р зорилтын хүрээнд:** Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд аймаг орон нутгаас 15,000,000 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, Ховд бороо-1,2 экспедицүүдийн бензин шатахуун болон бусад зардалд зарцуулж ажилласан. Энэ онд ЦАЗН-лөх үйл ажиллагааг ЦУОШГазрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ний А/123 тоот тушаалаар 2024 оны 05 дугаар сарын 22-нээс 09 дүгээр сарын 15 хүртэл 2 экспедиц нийт 18 удаа давхардсан тоогоор 27 удаа цаг агаарт зориудаар нөлөөлж 42 ширхэг пуужин харваж, ЦАЗ-аар нөлөөлөх үйл ажиллагааг Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсэг болон Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор, Өндөр уулын бүс нутгаар хур тунадас нэмэгдүүлэх, бэлчээрийн ургамлын ургалтыг дэмжиж зуншлагын байдалд таатай нөлөө үзүүлэх, аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, ган цөлжилтөд нэрвэгдэж байгаа бүс нутгийн байгаль орчны төлөв байдлыг дэмжих зорилготой үйл ажиллагаагаа явуулж ажилласан.

**ДЭЭД ГАЗАР, ОРОН НУТАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙСЭН АЖИЛ:**

- БОАЖЯ-ны сайдын багцаас 2024 онд 108,3 сая төгрөгний хөрөнгө оруулалт шийдэгдэж

төв, цаг уурын өртөө, харуулуудад хүчин чадал өндөртэй орчин үеийн суурийн болон зөөврийн компьютер 28 ш, 9 өртөөнд тус бүр хэвлэгч машин, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын багцаас 2024 онд 108.3 сая төгрөгний хөрөнгө оруулалт шийдэгдсөн бөгөөд 7 харуулд i5, байгууллагын нягтлан бодоход i7 1ш, сургалтын зориулалтаар i7 1ш зөөврийн, Урьдчилан мэдээлэх салбарт i9 2ш, 9 өртөөнд i7, байгууллагын инженер техникийн ажиллагсадад i7 5ш, i5 3ш суурин нийт 28 ширхэг компьютероор тус тус хангаж ажилласан. Мөн 9 өртөөг олон үйлдэлт А4 хар цагаан принтер, АМДСанг олон үйлдэлт А3 хар цагаан принтер, 8 өртөөнд “био-00” ариун цэврийн байгууламж болон 11 ус судлалын харуулуудын техникч нарт унааны асуудал шийдэж шаардлагатай байсан багаж төхөөрөмж, унаагаар хангасан нь ажилчдын ажиллах нөхцөл илт сайжирсан.












*Зураг. БОАЖЯ-н сайдын багцаас шийдсэн багаж тоног төхөөрөмж гардуулж, хүлээн авсан нь*

- УЦУОШТ-ийн дулааны шугамыг аймгийн төвийн дулааны шугамд холбох ажлыг 85 сая төгрөгний санхүүжилтээр хийгдэж, ажилчдын ажиллах тав тухай орчин бүрдсэн.






*Зураг.Төвийн дулаанд холбох газар шороо, сан техникын ажил*

- Аймгийн ИТХ-ын 14/4 тогтоолоор Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас ЦАЗ-аар нөлөөлөх үйл ажиллагааг Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсэг болон Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор, Өндөр уулын бүс нутгаар хур тунадас нэмэгдүүлэх, бэлчээрийн ургамлын ургалтыг дэмжиж зуншлагын байдалд таатай нөлөө үзүүлэх, аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, ган цөлжилтөд нэрвэгдэж байгаа бүс нутгийн байгаль орчны төлөв байдлыг дэмжих зорилгоор 15 сая төгрөг шийдвэрлүүлэн авч бензин шатахуун бусад зардалд зарцуулахад гэрээ байгуулж ажилласан.



*Зураг1. ЦАЗН үйл ажиллагааны гэрээ*

- Цаг уурын Мөнххайрхан өртөө сум хөгжүүлэх сангаас 5.000.000 сая төгрөгний санхүү шийдүүлж шинэ байрныхаа тохижилтонд шаардлага эд зүйлийн авч ажиллах таатай орчин нөхцөл бүрдүүлж ажилласан.




*Зураг.Тохижилтонд авсан эд зүйл*

- Цаг уурын Мөст өртөө ОНХ-н сангаас 5.000.000 сая төгрөгний санхүү шийдүүлж мэдээллийн урсдаг LED самбар авч байрлуулсан.
- Цаг уурын Дуут харуул орон нутгийн хөгжлийн сангаас 2.450.000 төгрөг шийдүүлж шаардлагатай багаж тоног төхөөрөмж худалдан авч, самбар үзүүлэн хийлгэсэн.




*Зураг. ОНХС-аас санхүүг шийдүүлж авсан багаж төхөөрөмж*

- Цаг уурын Дунд-ус өртөө нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Сумын ИТХ-ын 2024.09.16-ны өдрийн 20 дүгээр хуралдааны 01 дүгээр хавсралтаар ИТХ-ын Цаг уурын байгууллагын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрийн 9 сая төгрөг шийдүүлж, компанитай гэрээ хийж гэрээний дагуу бараа бүтээгдэхүүнээ нийлүүлэв.Үүнд: Ажлын ширээ- 3 ш, сандал- 3 ш, шкаф- 2 ш, буйдан- 1ш, сэтгүүлийн ширээ-1ш, i5 Dell note book 1 ш, хивс-1ш авч ажилчдын ажтллах тав тухтай орчин бүрдүүлсэн. Мөн 5.5 сая төгрөгний санхүүлжилтээр ХААЦУ-ын 50x50 талбайн төмөр хашаа шонг шидүүлсэн.











*Зураг.Өртөөнд СХС-аас шийдүүлсэн эд хөрөнгөө хүлээн авч байрлуулсан нь*

- Чандмань цаг уурын өртөө СХС-аас 5 сая төгрөгний санхүүжилт шидүүлж өрөөнийхөө тохижилтонд зориулж шкаб-2ш, ширээ-2ш, сандал-2ш, сүлжээний утас 100м, цемент-10ш шидүүлж ажилчдынхаа ажиллах орчин бүрдүүлсэн.




*Зураг.СХС-аас шийдүүлсэн бараа бүтээгдэхүүн*

- Манхан цаг уурын өртөө орон нутгийн хөгжлийн сангаас 1 сая төгрөг шийдүүлж AWS330 автомат станцад логерийн мэдээллийг шууд дэлгэцэд харахаар MWS-1.0 DATALOGGER маркийн дэлгэц авч тавьсан одоогоор цахилгаан эрчим хүч тасарсан үед мэдээллийн тасралтгүй байдал хангаж ажиллаж байна.




*Зураг. Логерийн тавьсан дэлгэц*

- Аймгийн онцгой комиссын шийдвэрээр засаг даргын нөөц хөрөнгөөс 3000000 төгрөгийг шийдвэрлүүлэн Масс мессеж үйлчилгээг 4500 иргэний гар утсанд дамжуулж 69 удаа үйлчилж ажилласан.
- Мянгад сумын иргэдийн хурлаар асуудлыг хэлэлцүүлж 6 дугаар сард хуралдах ИТХ -аар давсан орлогоос 5.5 сая төгрөгний санхүү шийдвэрлэж,11 дүгээр сард хөрөнгийн асуудал шийдэгдэж тендэр зарлагдаж заавар дүрмийн дагуу шон, хашааг татаж, харуулын талбайг 20х16 м2 хэмжээтэй болгож, төвийн багажийн инженер болон бусад ажилчид очиж багаж төхөөрөмжийг суурилуулж байрлуулах ажлыг хийж хүлээн авсан.





*Зураг. Талбайг 20х16 болгосон байдал*

- ЦУОШГ-аас салбар нэгжил шаардлагатай багаж төхөөрөмжөөр хангасан Үүнд: ХААЦУ-ын ургац жигнэдэг электрон жин 2ш, 50 метрийн урттай метр 2ш, тунадас хэмжигч хэмжүүрийн аяга 16ш,

**ОРОН НУТАГ, БАЙГУУЛЛАГААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛОН НИЙТИЙН АЖИЛ:**

*УЦУОШТ-ийн ажилчид аймаг орон нутгаас зохион байгуулсан олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог 2024 онд олон нийтийн ажилд оролцсон байдал:*

- Монгол улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, ерөнхий сайд Ховд аймагт ажиллаж, иргэд хөдөлмөрчидтэй хийсэн уулзалтанд байгууллагын дарга, 6 инженер, техникч оролцсон.
- БОАЖЯ-ны сайд асан Б.Батэрдэнэ БО-ны чиглэлийн байгууллагуудын ажилтан албан хаагчтай уулзалт хийхэд төвийн дарга, инженер, техникчид оролцож, цаг уурын байгууллагт ажиллаж байгаа ажиллагсдын нийгмийн асуудал, шинжилгээний хөтөлбөрт ажлын тасралтгүй үйл ажиллагааг явуулхад шаардлагатай багаж төхөөрөмжөөр хангах зэрэг шийдүүлэх санал хүсэлтээ тавьсан.
- Монгол улсад цаг уурын алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд байгууллагын нийт хамт олноос 10 сая төгрөгний хандив өгсөн.Тус баярын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу 1. Спортын 5 төрөлт тэмцээн, 2.ЭШБ хурал, музейн нээлт, 3.Баряын хурал, 4. Хүлээн авалт, 5. 3 үеийн уулзалт хэлэлцүүлэгт хуваарийн дагуу төвийн ажилчдаас 38 ажилтан, 20-өндөр настан нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.










*Зураг. УЦУ-ын 100 жилийн ойн арга хэмжээнд төвөөс оролцогчид*

- Мөнгөлөг шагшуурга-2024 арга хэмжээ 1 дүгээр сарын 19-21 хооронд зохион байгуулагдаж тус арга хэмжээнд төвийн хамт олон гэр барьж тохижуулах, хогийн сав,

тамихны иш хийх сав зэргийг хийж байршуулж ажилласны цэрэгцээ БО-ны салбарын байгууллагууд дунд зохион байгуулсан спорт, урлагын арга хэмжээнд баг бүрэлдэхүүн, хамт олноороо идэвхтэй оролцсон.




*Зураг.Мөнгөлөг шагшуурга-2024*

- “Эв нэгдэл-Спортоор манлайлая” аянд /3-р сарын 15-12-р сарын 15-ны хооронд/ төвийн хамт олон нэгдэж сарын бүрийн 3 дах 7 хоногийн 5 дах өдөр спортын үйл ажиллагаа явуулж,тогтмол заал авч бие бялдараа чийрэгжүүлж байна.




*Зураг. Хамт олон Аянд нэгдсэн, заал авч тоглож байгаа нь*

- Дэлхийн усны өдрийг тохиолдуулан жил бүр зохион байгуулдаг спортын 5 төрөлт тэмцээнд төвийн баг тамирчид оролцож, дартацаар алт, шатраар мөнгөн медиаль авсан амжилттайгаар оролцсон. БО-ны чиглэлийн байгууллагуудын дунд уламжлал болгон зохин байгууллагддаг спортын 5 төрөлт тэмцээнд төвийн баг хамт олон идэвхтэй оролцож, теннисээр алт, олс таталтаар мөнгөн медиаль авсан









*Зураг. 100 жилийн ойн тэмцээн*

- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийн сургалтын үйл ажилгаанд баг бүрэлдэхүүнээрээ жагсаж бэлэн байдлыг хангаж оролцсон.








*Зураг. Сургалтаар*

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гарагийг “БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР” хэмээн зарласан байдаг. Манай хамт олон Хаврын мод тарилтаа 100 ш мод тарьж, намрын тарилтаар тарьсан модны ургалтын арчилгаанд зориулж 200.000 төгрөг хурааж өгсөн.







*Зураг. Төвийн хамт олон хаврын мод тарилтаар 100 ш мод тарив*

- Төвийн хамт олон Баруун бүсийн ‘”ХОВД-ЭКО ЦЕМЕНТ”-ийн үйлдвэрийн үйл ажиллагаатай талилцсан.









*Зураг. Цементийн үйлдвэр эй танилцаж байгаа нь*

- Монгол орон даяар зохион байгуулсан “Номын баяр”-ны үйл ажиллагаанд хамт олноороо үнэдэсний хувцастайгаа оролцсон.





*Зураг. Номын баяраар*

- Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийг Гэр бүлийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэг болсонтой холбогдуулан ХГБХХГазраас “Хүүхдэд ээлтэй гэр бүл байя” уриан дор “Нэг байгууллага- нэг санаачлага” арга хэмжээг зохион байгуулж Жаргалант сумын 6-р цэцэрлэгийн дундын’’Б’’ бүлгийн багш, хүүхэд, эцэг эхчүүдийн дунд амжилттай зохион байгуулж тайланг хүргүүлж ажиллалаа. Энэ өдөр хүүхдүүд ээж

аавтайгаа тоглож, наадан дуртай зүйлсээ хийж нэг өдрийг дурсамж дүүрэн хөгжилтэй өнгөрүүлсэн арга хэмжээ зонхин байгууллаа.

- УЦУОШТ-н эцэг эхийн зөвлөл нь оны эхэнд төлөвлөгөө гаргаж байгууллагын удирдлагаар батлуулан ажилладаг ба энэ оны төлөвлөгөөнд 11 төрлийн ажил төлөвлөснөөс 100% биелэлттэйгээр хийж гүйцэтгэсэн. Байгууллагын ‘Хүүхэд хамгааллын бодлого’ ‘Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм’-ийг мөрдөж, байгууллагын дотоод журманд хэд хэдэн зүйлийг тусгаж ажилласан.Байгууллагын эцэг эхийн зөвлөл аймгийн номын сантай хамтран байгууллагынхаа ажилтан албан хаагчдыг хүүхдүүдийн хамт “Гэр бүлийн урилгат уншлага”-ыг зохион байгууллаа. Уншлаганд хамрагдсан гэр бүлүүд сонирхолтой ном уншиж, ээжүүд багийн ажлын тоглоом тоглож, тус байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, болор цомын эзэн Х.Эрдэнэбаатарын талаар мэдээлэл авч, хүүхэд багачууд “Аав-ээж” сэдвээр зураг зурж, ээжүүд хүслийн модонд хүслээ бичиж сэтгэгдлээ үлдээлээ.
- Хүүхдийн баярыг угтаж 5 дугаар сарын 31-нд өдөр төвийн нийт ажиллагсадын хүүхдүүдэд байгууллагаас бэлэг, өгч аав, ээжийнхээ ажилтай танилцлаа.









*Зураг. Эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан ажлууд*

- *“МОНГОЛ ХЭЛ БИЧИГ”* дэд хөтөлбөрийн хүрээнд дэд хөтөлбөрийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд доорх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Байгууллагын хүүхдийн болон амралтын өрөөний зориулалтаар ашигладаг өрөөг давхар Монгол бичиг сурах орчин бүрдүүлэн нэг буланд ширээ сандал байрлуулан монгол бичгийн гарын авлага, ном товхимол тавьж тохижуулан ажиллаж байна. Байгууллагын салбар нэгжүүдийн өрөөний хаягийг кирилл, монгол бичгээр хослуулан бичиж шинэчилж хийсэн, байгууллагын тамга, туг зэрэгт байгууллагын нэрийг монгол бичгээр бичсэн.







*Зураг. Монгол хэл бичгийн булан, монгол бичгийн сургалт*

- Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан “Монгол өв соёлоо дээдлэе” монгол бичгийн арга хэмжээнд байгууллагаас 6 хүний бүрэлдэхүүнтэй орлцож 2-р байранд шалгарсан.
- “Хос бичигтэн Ховдчууд” аяны хүрээнд үндэсний бичгээ эрхэмлэн дээдэлж түгээн дэлгэрүүлэх, төрийн албан хаагчдын монгол бичгийн хэрэглээний чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Ховд аймгийн соёлын газраас зохион байгуулж буй "Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг" уралдаанд тус төвийн хамт олны төлөөлөл оролцож монгол бичгийн мэдлэг чадвараа сорин өрсөлдлөө. Уралдаан түргэн уншлага, уран бичвэр, цахим бичвэр, багийн ахлагчийн даалгавар, монгол бичгийн дүрмийн асуулт хариулт гэсэн төрлүүдээр явагдсан ба нийлбэр дүнгээр 1-р байранд шалгарсан амжилтыг үзүүллээ. Ус судлалын салбарын инженер З.Бахатбол минутанд "хамгийн олон үг" 170 үг уншиж түргэн уншигчаар шалгарлаа.






*Зураг.Төвөөс оролцсон баг болон түргэн уншиг*

- ЗДТГазраас “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийг хэрэгжүүлэх дэд ажлын хэсгийн ХА-н төрийн албан хаагчидтай хийх уузлалтанд төвийн дарга А.Энхзаяа, хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан ажилтан Г.Нямсансар, Систем сүлжээний инженер Э.Ганцэцэг нар 2024 оны 01 дүгээр сарын 30-нд оролцсон.
- Мөнххайрхан цаг уурын конторын шинэ барилгын нээлтийн үйл ажиллагаа Туршлага судлах үйл ажилгаатай хамт зохион байгуулж хамт олноороо оролцсон.



*Зураг. Барилгын нээлт, сургалт*

***СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА:***

Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын сургалт, семинар, зөвлөлгөөнийг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, ажилчдыг сургаж чадавхижуулах ажлын хүрээнд: ***Дээд газраас зохион байгуулсан сургалт:*** -ЦУОШГазар дээр зохион байгуулагдсан удирдах ажилтаны зөвөлгөөнд төвийн дарга А.Энхзаяа 4 дүгээр сард оролцсон.

- БОАЖЯамнаас зохион байгуулсан “Агаар чанарын хяналтын нэгдсэн систем Монголд” сургалтанд БОШЛ-н эрхлэгч инженер С.Жавзанпагма БНСУ-д оролцож туршлага судалсан.




*Зураг. БОШЛ-ийн инженерүүдийн сургалтаар*

- ЦУОШГазраас 2024.01.08-нд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй сургалтыг цахимаар зохион байгуулж төвийн нийт албан хаагчид оролцов.









*Зураг. Сургалтанд оролцож буй өртөөний хамт олон*

- ЦУОШГ-аас зохион байгуулсан цахим хурал УСУАҮХ-ийн ахлах мэргэжилтэн Амгалан хийсэн энэ хуралд аймгуудын МҮХ-ийн дарга нар цахимаар орлцсон.
- ЦУОШГ-ын УСУАҮХ-ийн ахлах мэргэжилтэн Н.Энхмаа цахим хурал, хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж аймгуудын ЦУОТХ-ийн дарга нар, багаж, цаг уурын салбар хариуцсан инженерүүд оролцсон. Үүрэг даалгавар 11-ийг өгснөөс 10 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хийж, тайлан мэдээгээ хүргүүлж, 1 ажил 2025 онд хийгдэхээр болсон.
- Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн чанарыг дээшлүүлэх асуудлаар цахим уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 10-нд зохион байгууллаа, уулзалтаар өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн чанарт үр дүнгийн шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тандалт судалгаа хийсэн дүн, мэдээллийг танилцуулж, тайлан мэдээ боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, иргэдээс ирүүлж байгаа өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанарыг дээшлүүлэх талаар санал солилцлоо уулзалтанд хүний нөөц, бичгийн ажилтан Г.Нямсансар оролцлоо.



*Зураг. Сургалт*

- ТАЗ-өөс явуулдаг 4 дэх өдрийн 7:4:10 цахим сургалтанд манай хамт олон идэвхтэй оролцдог.
- Нислэгийн цаг уурын төвөөс зохион байгуулсан орон нутгийн синоптик инженерүүдийн давтан сургалтанд төвийн 1 инженер хамрагдсан.



*Зураг. Сургалтанд оролцсон инженер*

- НЦУТ-өөс Нислэгийн цаг уурын мэдээгээр хангах журам, Онцгой тохиолдолд ажиллах журмын талаар цахим сургалт хийхэд УМС-ын инженерүүд бүрэн хамрагдсан.
- АДАПТ төслөөс Говь-Алтай аймагт зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” сэдэвт сургалтанд төвийн дарга А.Энхзаяа, хэлтсийн дарга Ц.Дэлгэр, М.Баярмаа, УАҮ-ний салбарын инженер Ж.Ганбаяр нар оролцсон.



*Зураг. Сургалтанд төвөөс болон аймгаас оролцогчид*

- Улаанбаатар хотод ЦУОШГ, хамтран зохион байгуулсан “Цаг агаарын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ” сэдэвт сургалтанд МҮХ-ийн дарга М.Баярмаа, УАҮ-ний салбарын инженер Ж.Ганбаяр, ЦАЗН-х салбарын мэдээлэл хариуцсан инженер П.Мягмардорж нар оролцсож гэрчилгээ авсан.



*Зураг. Сургалтанд оролцогчид*

- УЦУОСМХ-ийн УМ-ийн ахлах мэргэжилтэн А.Батболд мэдээ дамжуулах, зураг мэдээ татах, прогноз зураг боловсруулах талаар сургалтыг манай төв дээр 6 дугаар сарын 24-нд хийсэн.




Зураг. Сургалтаар

-Архивын ерөнхий газраас, ЦУОШГазрын салбарын ажилтануудад “Баримт бичгийн стандарт”, “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавигдах үндсэн шаардлага” стандарт сэдэвт сургалтыг цахимаар 2024.11.28-нд, ЦУОШГазрын Захиргаа аудитын хэлтсээс харъяа байгууллагуудын байгууллагын архив хариуцсан албан хаагчдад “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” “Байгууллагын архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт, Хагас болон бүтэн жилийн тайлан бичэхэд анхаарах зүйлс зэргээр сургалтыг цахимаар 2024.12.02-нд тус тус зохион байгуулж Хүний нөөц, байгууллагын архив бичиг хэргийн ажилтан Г.Нямсансар оролцсон.









*Зураг. Архивын ерөнхий газар, ЦУОГазраас зохион байгуулсан сургалт*

***Орон нутгаас зохион байгуулсан сургалт:*** СХЗГазраас зохион байгуулсан сургалтанд оролцож мэдээлэл хийж туршлага судалсан.



*Зураг.Сургалт*

- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд 2024 оны 03 дугаар сарын 26-нд Нансалмаа, Амарзаяа, Отгонжаргал, Хаш-эрдэнэ, Оюунтунгалаг нар хамрагдав.
- МУЗГазрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай, Зөрчлийн тухай хуулиуд, тэдгээрийн дагаж гарсан дүрэм журам, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтанд 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Отгонтөмөр, Жавзанпагма нар оролцсон.
- Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас зохион байгуулж байгаа "Цахимд хэвшье DIGITAL FIRST-D1" сургалтанд 2024 оны 04 дүгээр сарын 05-нд Ганцэцэг, Нямбаяр, Нямсансар, Мягмардорж, Жаргалсайхан нар оролцсон.





*Зураг.Сургалтанд оролцогчид*

- МУИСургуулийн Баруун бүсийн салбар сургуулийн Химийн тэнхимээс зохион байгуулсан Метрохимийн анхан шатны сургалтанд инженерүүд сууж СЕРТИФИКАТ авсан.
- Орон нутгийн байгаль орчны манлайлал хөтөлбөрт сургалтанд УБ хотод 7 хоног инженер Нансалмаа суралцан сертификат авсан.






*Зураг. Сургалтанд хамрагдаж ГЭРЧИЛГЭЭ авсан инженер*

- АТГазраас цахимаар 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Авилгын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулж тус төвийн болон өртөө харуулын албан хаагчид оролцсон.









*Зураг. АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтанд*

- “Хүний эрхийн нөхцөл байдал” сургалтад орчны бохирдлын талаар мэдээлэл хийж оролцсон
- “Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө гаргах, батлах” сураглтанд инженерүүд сууж, мэдээлэл өгсөн.
- Аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал сургалт болон бусад сургалт мэдээллийн цагт хамрагдсан.



*Зураг. Сургалтуудад оролцсон байдал*

- ХГБХХГазраас 2024.10.16-нд зохион байгуулсан байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн сургалтанд УАБ-н ахлах техникч П.Энхжаргал, Нислэгийн цаг уурын техникч Э.Оюунтунгалаг нар оролцсон. -Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, ЗДТГазраас хамтран зохион байгуулсан Иргэдийн төрийн байгууллага, албан тушаалтанл гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж, анхаар асуудал сэдэвт сургалтанд төвийн дарга, МҮХэлтсийн дарга, Хүний нөөц, байгууллагын архив бичиг хэргийн ажилтан нар сургалтанд хамрагдсан.





*Зураг. ЗГ-н хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан*

- Байгууллагын инженер техникчид мэргэжлийн журамласан үгийг хэрхэн бичих, монгол бичгийн зөв бичих дүрмээр мэргэжлийн багшаас 2-цагийн багц хичээлийн сургалт авсан. Хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан ажилтан танхим болон цахим сургалтаар өөрийн монгол хэл бичгийн мэдлэгээ чадвхижуулан суралцаж байгаа.

***Байгууллагаас зохион байгуулсан сургалт:*** Улирлын чанартай ажиглалт эхлэхтэй холбогдуулан Ус судлалын салбарын сургалтыг танхимаар зохион байгуулсан. Тус сургалтанд гол, нуур, мөстлөг судлалын 12 харуулын техникч нар оролцлоо. Сургалтаар өнгөрсөн оны шинжилгээний ажлын үр дүн, алдаа дутагдалын талаар болон БОШЛ-ийн инженер С.Жавзанпагма усны химийн сорьцын авах, шинжилгээний ажлын талаар сургалт өгсөн.

- УЦУОШТөвөөс цаг уурын 9 өртөөний дарга, 7 харуулын техникчдэд 2024 оны нэгдсэн сургалтыг зохион байгуулж, сургалтанд нийт цаг уурын өртөө, харуулын 20 техникч, салбар хариуцсан 9 инженер техникчид нийт 30 гаруй ажилчид хамрагдаж батлагдсан хөтөлбөр, сэдвийн дагуу салбар хариуцсан инженер, ахлах техникчид онолын хичээл заасны зэрэгцээ станц харуулын ажиглалтанд гарч буй үл тохирол, цаашид цаг агаарын үзэгдлийг хэрхэн зөв ажиглах, ажиглалтын мэдээг хэрхэн зөв кодлох, дамжуулах талаар заавар зөвлөмжийг өглөө.
- БОАЖЯ-ны сайдын багцаас цаг уурын өртөө, харуулуудад шийдэж өгсөн суурин болон зөөврийн компьютерүүдийг нь гардуулж өгсөн.



*Зураг.Сургалт,компьютер хүлээгэн өгсөн нь*

- Цаг уурын өртөөдийн “Туршлага судлах нэгдсэн сургалт”-ыг 5 дах жилдээ Мөнххайрхан сумын Мөнххайрхан цаг уурын өртөөний хамт олон 2024 оны 05 дугаар сарын 23-24-ны өдөр зохион байгуулав. Сургалт батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагаа явагдаж, сургалтанд төвийн инженер, техникчид болон цаг уурын 9 өртөө, цаг уур ус судлалын харуулуудын нийт 60 гаруй ажилтан албан хаагчид оролцсон.



➢ 





*Зураг. Туршлага судлах сургалт*

- Байгууллагын сургалтын хөтөлбөрийн дагуу нийт 9 удаа сургалт авч ажилчдынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтуудыг авч ажилласан. Жич: Хавсралт-2 Сургалтын дэлгэрэнгүй тайланд тусгасан.

- Сар бүрийн 2 дахь, 4 дэхь 7 хоногийн Лхагва гарагийн 14 цагаас мэдээллийн цаг болгон ажилтан албан хаагчдад өөрсдийн сонирхсон мэдээ, мэдээлэл болон төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой мэдээллээ аймагт үйл ажиллагаагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудад санал хүсэлтээ тавьж төлөвлөгөөний дагуу Прокурын газраас “Гэмт хэрэгтэй тэмцэх”, засаг даргын тамгын газрын хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн “Төрийн албаны тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар, “Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай”, НДХ-ээс “Тэтгэвэр тэтгэмжийн даатгалын тухай”, аймгийн ХГБХГ-аас “Хүүхдийн эрхийн тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль”, ” Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Архидан

согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” сэдвүүдээр тус тус сургалт мэдээлэл авч ажилласан байна.



*Зураг. Мэдээллийн цагаар Хууль эрх зүйн болон бусад чиглэлээр мэдээлэл авч байгаа нь*

## ***ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, БОЛОВСОН ХҮЧНИЙ ХАНГАЛТЫН ТАЛААР***

2024 оны байдлаар тус УЦУОШТөв нь дараахь бүрэлдэхүүнтэйгээр ажил үйлчилгээг явуулж ирлээ. Үүнд: Захиргаа санхүү, аж ахуйн хэлтэс, ЦУОТХэлтэс, МҮХэлтэс гэсэн 3 хэлтэстэйгээр, төвийн дарга 1, аж ахуйн ажилтан 4, хэлтсийн дарга 3, технологич инженер 11, Өртөөний дарга 9, Төвдөө ахлах техникч 13, Өртөөний ээлжийн техникч 36, Ус судлалын техникч 11, ХАА-н цаг уурын харуулын ажиглагч 7, Мөстөл судлалын техникч 1, үндсэн 96 ажилтантай УЦУОШинжилгээний хөтөлбөр ажлыг гүйцэтгэж ирлээ.

Нийт ажиллагсад нь Магистр – 8, Бакалавр – 52, Тусгай дунд – 10, Мэргэжлийн курсээр бэлтгэгдсэн мэргэжлийн үнэмлэхтэй – 26 ажилтан ажилчид ажиллаж байна.

Цаг уурын инженер мэргэжилтэй-29, цаг уурын техникч мэргэжилтэй - 6, бусад мэргэжлийн - 15, цаг уурын курсаар бэлтгэгдсэн ажиглагч - 46 байна.

Тус төвд ажиллаж байгаа албан хаагчид нь тухайн байгууллагад 2 сараас 38 дахь жилдээ ажиллаж байна.

УЦУОШТөвд ажиллаж байгаа хүмүүсийг насны ангиллаар авч үзвэл:

20-30 насны 15 хүн буюу 15.6%

31-40 насны -21 хүн буюу 21.9%

41-50 насны 36 хүн буюу 37.5%

51-ээс дээш насны 24 хүн буюу 25% ажиллаж байна.

УЦУОШТөвд ажиллаж байгаа хүмүүсийг хүйсээр нь авч үзвэл:

Эрэгтэй-35

Эмэгтэй-61

Одоогийн байдлаар төв орон нутгийн ус цаг уурын салбарууд мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан гэж үздэг.

2024 онд мэргэжлийн боловсон хүчний хангалтаас шалтгаалсан зөрчил гараагүй үйл ажиллагаа хэвийн явагдлаа.

***Салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх:***

Төвийн салбар нэгжийн боловсон хүчнээр хангах 2024 онд Цэцэг өртөөний дарга Н.Даваадорж, Дунд өртөөний техникч Н.Бахатгүль, Х.Хуатбек, ХАА-н ахлах техникч Ж.Жаргалзаяа, Байтаг өртөөний дарга Д.Чулуунцэцэг нар өндөр насны тэтгэвэрт гарсан. Мөнххайрхан өртөөний техникч өөр өртөөнд шилжсэн зэрэг 5 сул ажлын байр гарсан зарын дагуу анхан шатны материалын шаардлага хангасан 10 хүнийг хөтөлбөрийн дагуу сургаж дадлагажуулсанаас Мөнххайрхан өртөөний техникчээр 2024.03.12-ны өдрийн Б/05 тушаалаар Ч.Цэнгэлийг, Цэцэг өртөөний техникчээр 2024.05.01-ний өдрийн Б/13 тушаалаар Г.Ганзоригийг, Дунд ус өртөөний техникчээр 2024.08.01-ний өдрийн Б/27 тушаалаар Х.Гүлбаршинийг, Дунд ус өртөөний техникчээр 2024.11.01-ний өдрийн Б/46 тушаалаар Х.Оразайг, ХАА-н ахлах техникчээр 2024.12.01-ний өдрийн Б/53 тушаалаар О.Шинэ-одыг тус тус томилон ажиллуулж байна.

Салбаруудад 2024 онд шинээр ажилд томилогдсон 4 албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг үүсгэн холбогдох баримт бичгийг /албан тушаалд томилогдсон тушаал, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн анкет, дипломын натаратаар батлуулсан хуулбар, намтар гэх мэт/ бүрдүүлж авсан.

Төрийн албан байгууллагын ажилтны үндсэн мэдээллийг бүртгэх, тухайн ажилтантай холбоотой ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөн, цалин хөлс, нэмэгдэл цалингийн суурь мэдээллийг оруулах, тайлагнах зориулалттай Төрийн албаны ХНУМТ цахим систем байгууллагын албан хаагчдийн мэдээллүүдийг шинэчлэн бүртгэж, нийт ажилчдны хоол, унааны хөнгөлөлтийг ажилтан тус бүрээр, үндсэн цалин, нэмэгдэл цалин хөлсийг тухайн сард нь өөрчлөлт орсон ажилтаны хөдөлгөөнийг тухай бүрд нь шинэчлэн бүртгэсэн.

Ажлын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, шатлан дэвшүүлэх зарчим баримтлан 2024 онд Цэцэг цаг уурын өртөөний даргаар ээлжийн техникч Ш.Хэнмэдэхийг, төвийн ХААЦУ-ын ахлах техникч тэтгэвэрт гарсантай холбогдон Ховд цаг уурын өртөөний дарга О.Шинэ-Одыг, Ховд өртөөний даргаар ээлжийн техникч Л.Нямцэцэгийг, Байтаг цаг уурын өртөөний дарга Д.Чулуунцэцэгийг гарсантай холбоотой төвийн албан хаагчийн бүртгэлд байдаг мэргэжлийн Ц.Цэцэгмааг шатлан дэвшүүлэх зарчимаар ажилд томилсон.

Ажилтнуудыг зэргийн шалгалтад хамруулах, ажлын үр дүн гаргасан ажилтнуудыг шагнаж урамшуулах, төрийн одон медальд тодорхойлох, төвийн нийт ажиллагсдын нийгмийн зарим асуудлыг байгууллагын дотоод журмын дагуу зохион байгуулах ажлын хүрээнд:

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэжлийн зэрэг олгох журмын дагуу төвд ажиллаж байгаа мэргэжлийн инженерүүдээс тухайн ажлын байранд 3-аас дээш жил ажилласан 5 инженер, 2-аас дээш жил ажилласан 16 өртөө, ХАА-н харуулын техникч, 8 ус судлалын харуулын техникч мэргэжлийн зэргийн шалгалтанд орох хүсэлт, материалаа бүрдүүлж ЦУОШГ-ын мэргэжлийн зэрэг шалгаруулах комиссд хүргүүлэн зэргийн шалгалтыг өгч, үүнээс 3 инженер, 8 өртөө харуулын техникч, 6 ус судлалын харуулын техникч нийт 17 албан хаагч зэргийн шалгалтанд тэнцэж 2024 оноос зэргийн нэмэгдэлийг авсан бөгөөд нийт 51 ажилтан зэргийн нэмэгдэл авч байна.

Монгол Улсад Ус цаг уурын алба үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойгоор өндөр настан Ц.Идэш “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”, өндөр настан Р.Цагаанцоож, Т.Цэцэгсүрэн Ш.Содномбалжир “Алтан гадас”, “Архив мэдээллийн дэд сангийн ерөнхий технологич инженер Ч.Цэрэнханд “Хөдөлмөрийн хүндэт”, Дунд ус өртөөний техникч Х.Хуатбек, Мөстөл судлалын техникч Я.Батцэнгэл, Байтаг өртөөний техникч О.Даваадолгор, Б.Батцэцэг, Мөнххайрхан өртөөний дарга Х.Өлзийсайхан, Мөнххайхан өртөөний техникч У.Даваажаргал, Ч.Нансалмаа, П.Анхтуяа, Уур амьсгалын ахлах техникч П.Энхжаргал, Б.Даваабал, Хүний нөөц, байгууллагын архив бичиг хэргийн ажилтан Г.Нямсансар, Мөстөл судлалын инженер Т.Хаш-эрдэнэ, Ус судлалын инженер З.Бахатбол, Цэцэг өртөөний техникч П.Эрдэнэбилэг, Дарви ХАА-н харуулын техникч Д.Цолмон, Хар ус-Дөргөн УС-н харуулын техникч Д.Бадамгарав, ЦАЗНөлөөлөх үйлчилгээний судалгаа, радар хариуцсан ерөнхий инженер П.Мягмардорж, Синоптик инженер Ж.Батцэцэг, Мөст өртөөний техникч Б.Цэнд-аюуш, Улаан ам-Эрдэнэбүрэн ус судлалын харуулын техникч Я.Батгэрэл БОЯамны “Тэргүүний ажилтан”-аар, Ховд өртөөний техникч Д.Отгонцэцэг, Төгрөг-Манхан ус судлалын харуулын

техникч Д.Жаргалмаа, Зэрэг өртөөний техникч С.Энхмаа, М.Туулцэцэг, Манхан өртөөний техникч Б.Жавзандулам БОАЖЯамны “Жуух бичиг”-ээр нийт 30 албан хаагч шагнагдсан. Төрийн дээд шагнал “Хөпдөлмөрийн хүндэт” медальд ХАА-н ахлах техникч Ж.Жаргалзаяа, Байтаг өртөөний дарга Д.Чулуунцэцэг, Цаг уур орчны технологийн хэлтсийн дарга бөгөөд орчны хяналт шинжилгээ хариуцсан ХАА-н цаг уурын технологич инженер Ц.Дэлгэр, Уур амьсгалын үйлчилгээ хариуцсан технологич инженер Ж.Ганбаяр, Холбоо мэдээллийн салбар хариуцсан ерөнхий технологич инженер Э.Ганцэцэг нарыг тодорхойлж холбогдох газарт нь хүргүүлсэн.

Байгууллагын дотоод журамд заасны дагуу төвийн нийт ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарим асуудлыг зохион байгуулж, 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар эрүүл мэндийн шалтгаанаар эмчилгээ сувилгаанд явсан, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн, ар гэрт гачигдал гарсан, хурим найр, ажилчдын гэр бүлд шинэ хүүхэд мэндэлсэн, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадад хүндэтгэл үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд нийт 15.515.000 төгрөгийн тусламж дэмжлэгийг байгууллагын хамтын сангаас үзүүлж ажилласан.

Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албаны Ёс зүйн хуулийн дагуу байгуулласан байгууллагын дэрэгдэх Ёс зүйн дэд хороо нь хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах ажлын хүрээнд:

Монгол улсын их хурлын 2023 оны 5 дугаар сарын 4-ны өдөр гарсан, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдон байгууллага дээр Ёс зүйн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр байгуулан ажиллаж байна. Хороон тусгай ажиллах журмын дагуу ажил үүргээ явуулж байгаа ба хорооны гол хийх ажилуудын нэг нь албан хаагчдаа ёс зүйн зөрчил гаргахгүй байх чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Энэ онд нийт ажилчдаас ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.



*Зураг. Ёс зүйн дэд хороо байгуулсан тушаал*

Байгууллагын Ёс зүйн дэд хороо төвийн албан хаагчдад ёс зүйн хуулиар мэдлэг олгох үүднээс Ховд аймгийн Хууль зүйн хэлтэсээс “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” , “Авилгын тухай ойлголт, авилгын эсрэг тухай” хуулиар нийт ажилчдад сургалт зохион байгуулж ажиллав. Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан цахим сургалтанд оролцсон.




*Зураг2. Төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлийн сургалт*

Төрийн албан хаагчийн ёс зүй, “Төрийн албаны шинэтгэл” сэдэвт сургалтыг МУлсын гавьяат хуульч Идэрсүрэн аймгийн ЗДТГазар хамтран Ховд аймгийн төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтанд төвөөс 4 албан хаагч оролцсон.



*Зураг. Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар орсон сургалтууд*

**Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн зохион байгуулсан ажил:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 1/1145 дугаартай албан бичгээр ирсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тус байгууллагын даргын Байгууллагынхаа эцэг эхчүүдэд хүүхдийнхээ сурлага, сурч буй орчинтой танилцах, хариуцан ажиллаж байгаа багш, удирдлагуудтай уулзах, хуралд оролцох, эцэг эхийн эргүүл хийх боломжоор хангаж, төрийн албан хаагчийн гэр бүлдээ гаргах цаг завыг зохицуулах, гэр бүлдээ халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор хүүхдийнхээ төрсөн өдрийг тэмдэглэхэд нь тус тус 1 өдрийн цалинтай чөлөөг олгодог ба хүүхдийн төрсний гэрчилгээг үндэслэн олгож бүртгэл хөтлөж ирсэн.


ГАДУУР АЖИЛ
БОЛОН ЧӨЛӨӨНИЙ
БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР

2019 он







*Зураг.Чөлөөний бүртгэлийн дэвтэр хөтлөлт,хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар*

Жил бүрийн 5 сарын 15-ны өдрийг Гэр бүлийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэг болсонтой холбогдуулан ХГБХХГазраас Хүүхдэд ээлтэй гэр бүл байя уриан дор **“Нэг байгууллага - нэг санаачлага**” арга хэмжээг зохион байгуулж ажиллахтай холбогдуулан Жаргалант сумын 6-р цэцэрлэгийн дундын’’Б’’ бүлгийн багш, хүүхэд, эцэг эхчүүдийн дунд амжилттай зохион байгуулж тайланг хүргүүлж ажиллалаа. Энэ өдөр хүүхдүүд ээж аавтайгаа тоглож, наадан дуртай зүйлсээ хийж нэг өдрийг дурсамж дүүрэн хөгжилтэй өнгөрүүллээ. 11 сарын 16-ны өдөр байгууллагын эцэг эхийн зөвлөл аймгийн номын сантай хамтран байгууллагынхаа ажилтан албан хаагчдыг хүүхдүүдийн хамт **“Гэр бүлийн урилгат уншлага”**-ыг зохион байгууллаа. Уншлаганд хамрагдсан гэр бүлүүд сонирхолтой ном уншиж, ээжүүд багийн ажлын тоглоом тоглож, тус байгууллагын үйл ажиллагаатай танилцаж , Болор цомын эзэн Х.Эрдэнэбаатарын талаар мэдээлэл авч, Хүүхэд багачууд аав ээжийн сэдвээр зураг зурж, ээжүүд хүслийн модонд хүслээ бичиж сэтгэгдлээ үлдээлээ. “Гэр бүлийн харилцаа, хүчирхийлэл, хүчирхийллээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? ” сургалт, “Нэг байгууллага -нэг санаачлага” арга хэмжээ, Хүүхдийн баярыг тохиолдуулан 5 дугаар сарын 31 –ний өдөр төвийн нийт ажиллагсадын хүүхдүүдэд байгууллагаас бэлэг өгсөн нь


























*Зураг.Хүүхэд гэр бүлийн талаар хийсэн ажилууд*

Байгууллагын гаднах ногоон орчин бүрдүүлэх зорилгоор байгууллагын гаднах модыг тайрах, ургамлын өт хорхойноос хамгаалж шохойдох, гадна талбайд садны гоёлын цэцэг суулгах ажил хийсэн.











*Зураг. Байгууллагын гаднах ногоон орчин бүрдүүлэх ажлаар мод, цэцэг тарьж байгаа нь*

Аймгийн хэмжээгээр өвлийн улиралд хариуцсан зам, талбайн цас цэвэрлэх, хаврын их цэвэрлэгээний ажил 4 дүгээр сарын 10-аас хийгдэж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын гаднах орчин, хааш хаашаагаа 50 метр газрын хог цэвэрлэх, Буянт голын ай сав дагуу газрыг цэвэрлэх гэх мэт цэвэрлэгээний ажилд манай хамт олон идэвхитэй оролцож ажилладаг.













*Зураг.Байгууллагын гаднах орчны хог цэвэрлэх, байгууллагын хашаа хайс будах, цас цайлуулах, Буянт голын дагуу хог цэвэрлэх ажил хийж байгаа нь*

## ГУРАВ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Байгууллагын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг тухай бүрд хүргүүлэн ажиллаж, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь тухай бүр цахим мэдээлэлд сар бүр байршуулан ажилласан. 2025 оын Төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн хэмнэлтийн 2024/04/25 ны дотор ЦУОШГазарт хүргүүлсэн. 2024 оны санхүүгийн мэдээ, тайланг үнэн зөв хийж НББОУС болон үндэсний стандартын дагуу мөрдөж байгууллагын санхүүгийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Төвийн 2024 оны төсвийг баглагдсан зориулалтын дагуу зарцуулж өр авлага үүсгэхгүй , төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг сар бүр хүргүүлж ажилладаг. Эд хөрөнгийн тооллогыг 2024 оны эхний 11 сарын байдлаар хийж Германы хамтын ажиллагааны KFW- төслөөс 5 нэр төрлийн нийт 7 ширхэг 27,5 сая төгрөгний багаж хэрэгсэлийг хүлээн авсаныг байгууллагын орлогод бүртгэн авсан.



*Зураг. Тушаалаар хүлээн авсан нь*

Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын 2024 оны А/80 тушаалын дагуу нийт 128.3 сая төгрөгний худалдан авалтыг амжилттай зохион байгуулж, суурин компьютер i9 2ш, i7 16ш, i5 3ш, зөөврийн компьютер i5 7ш, i7 2ш, олон үйлдэлт принтер 9ш, А3 олон үйлдэлт принтер 1ш, эко ариун цэврийн байгууламж 8 ширхэгийг тус тус цахим болон шууд худалдан авах ажиллагаар хийсэн.




Зураг. Салбар нэгжид өгсөн компьютер, перинтер гардуулж, хүлээн авсан нь

## ДӨРӨВ. ШИНЖИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРТ АЖЛЫН ХҮРЭЭНД

### *4.1. Цаг уурын шинжилгээний хөтөлбөрт ажлын талаар:*

Харъяа салбарууд болох 9 станц, 7 харуул, нарны цацраг судлалын станцын сар бүрийн шинжилгээний ажлын материалд техник болон шүүмж шалгалтыг хийж сар бүрийн 15-20-ны хооронд мэдээллийн дэд сан, УЦУОСМХүрээлэнгийн уур амьсгал нөөцийн судалгааны хэлтэст хүргүүлж ажиллаа.

Сар бүрийн хариу зааварчлагааг цахим хэлбэрээр хүргүүлсэн нь цаг хугацаа хожих дараа сарын тайланд алдааг дахин гаргахгүй байх, алдааг цаг тухайд засаж залруулах сайн талтай байлаа.

2023 онд гаргасан салбаруудын алдааны давтагдал, нийтлэг алдаа, салбар бүрийн байнга давтагдаж байсан алдааг засах арга замын талаар дэлгэрэнгүй шүүмж шалгалтын зааварчлага бичиж бүх салбаруудад хүргүүлсэн.

2024 оны уур амьсгалын жилийн эмхтгэлийг бичиж, элементүүдээр зураглалыг боловсруулж, тойм бичиглэлийг хийж, Веб сайтад байршуулсан.

Харъяа салбаруудын цаг уурын шинжилгээний ажлын тайлан ЦД-5 дэвтэр 85ш, ЦД-1 дэвтэр 108 ш, харуулын ЦД-7 дэвтэр 84ш мөн термотууз 3285ш, гигротууз 3285ш, барографийн тууз-401 бусад материалуудад шүүмж шалгалт хийж хугацаанд төвд хүргүүлж шалган зааварчлуулж ажилласан. Ажиглалтын чанар 90.7 хувь , тайлангийн ирц 99.94 хувь,

хөтөлбөрийн биелэлт 100 хувь, мэдээ зохиолт 91.16 хувиар ба жилийн нийлбэр дүн 94.816 хувьтай дүгнэгдсэн.
Шүүмж шалгалтын дүн -99.36 хувь , Шүүмж шалгалтын ажиглалтын чанар -99.5 хувьтай шалгагдсан.

САЛБАРУУДЫН 2024 ОНЫ ЦАГ УУРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН НЭГДСЭН ДҮН

| № | Өртө өний нэрс | т/и | х/б | а/ч | м/б | м/з | Дун-даж | Байр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байтаг | 100 | 100 | 96.92 | 96.46 | 95.76 | 97.828 | I |
| 2 | Дунд-ус | 100 | 100 | 93.92 | 94.92 | 78.04 | 93.376 | IX |
| 3 | Мөст | 100 | 100 | 95.67 | 94.38 | 97.38 | 97.486 | III |
| 4 | Манхан | 100 | 100 | 96.58 | 97.42 | 93.04 | 97.408 | IV |
| 5 | Зэрэг | 100 | 100 | 96.24 | 97.66 | 90.5 | 96.88 | V |
| 6 | Мөнххайрхан | 100 | 100 | 97.16 | 97.79 | 93 | 97.59 | II |
| 7 | Чандмань | 100 | 100 | 87.83 | 94.34 | 87.21 | 93.876 | VIII |
| 8 | Цэцэг | 100 | 100 | 89.58 | 93.12 | 95.5 | 95.64 | VI |
| 9 | Ховд | 100 | 100 | 92.62 | 94.38 | 88.29 | 95.058 | VII |

Цаг уурын өртөөдөөс шинжилгээний ажлын алдаа дутагдал нь засрахгүй байгаа Цэцэг өртөөнд 2024 оны 08 сарын 12-23-ны өдрүүдэд салбарын ахлах техникч Энхжаргал, Даваабал нар тус өртөөнд очиж ажилласан. Ажиллах хугацаандаа батлагдсан хөтөлбөрийн дагуу өртөөний дарга техникч нарт цаг уурын шинжилгээний ажлын талаар хичээл заах, гаргасан алдаа , эргэлзээтэй ойлгохгүй байгаа зүйлсийг нь тайлбарлан өгч харилцан ярилцаж ажиллалаа.

ЦАГ УУРЫН ХАРУУЛУУДЫН ДҮН

| № | Харуул нэрс | т/и | х/б | а/ч | м/б | м/з | Дундаж | Байр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үенч | 100 | 100 | 91.5 | 93.92 | 93.71 | 95.826 | I |
| 2 | Дөргөн | 100 | 100 | 80.79 | 91.34 | 89.66 | 92.358 | V |
| 3 | Дуут | 100 | 100 | 90.83 | 89 | 96.83 | 95.332 | II |
| 4 | Дарви | 100 | 100 | 90.53 | 87.92 | 96.74 | 95.038 | III |
| 5 | Мянгад | 100 | 100 | 85.08 | 86.66 | 96.76 | 93.7 | IV |
| 6 | Эрдэнэбүрэн | 99 | 100 | 81.62 | 85.88 | 88.2 | 90.94 | VI |
| 7 | Алтай | 100 | 100 | 84.92 | 80.25 | 77.99 | 88.632 | VII |

***4.2. ХААЦУ-ын шинжилгээний хөтөлбөрт ажлын талаар:***

ХАА-н цаг уурын ажлыг батлагдсан хөтөлбөрийн дагуу ажиглалт судалгааг цаг уурын 9 өртөө, ХАА-н Цаг уурын 7 харуулд бэлчээрийн, Байтаг өртөөнд таримал ургамлын үзэгдэлзүйн ажиглалт, бэлчээрийн зонхилох хөнөөлт шавьж, мэрэгчдийн ажиглалт, бэлчээрийн төлөв байдлын ажиглалт, Ховд өртөө хөрсний байнгын чийгшлийн, өвлийн цасны явуул судалгааны ажиглалт зэрэг ХАА-н цаг уурын хөтөлбөрт тусгагдсанаар энэ оны байдлаар өвлийн цасны явуул судалгааны ажлыг 17 сумын 84 зогсоол цэгт хийж ХХ-2б-84ш, мэрэгчдийн тархалтын голомт нутгийн зураглал тайлан 16ш, ХД-1-49ш, ХД-1а-37ш, ХД-2-5ш, ХД-7б-96ш, БТБ-ын ХД-8-84ш, нийт 271 ширхэг дэвтэр салбаруудаас ирсэн ХААЦУ-ын шинжилгээний дэвтэр тайланд техникч нар дэлгэрэнгүй шалгалт хийж, алдаа бичиж өгсөн тайланд онолын шалгалт хийж, салбаруудад гарсан алдааг дахин шалгаж, үнэлгээ өгч хариу

зааварчилгааг хүргүүлж ажилласан.тайланд техник болон онолын шалгалт хийж, харъяа салбаруудад сар бүрийн хариу зааварчилгааг бичиж байр эзлүүлэн тогтмол цахим байдлаар хүргүүлж ажилласан. 2024 оноос ЦУОШГ-аас бүх салбаруудын шинжилгээний ажлыг шинэчлэгдсэн журмаар ажлаа дүгнэсэн учир салбаруудын ажлын үзүүлэлт өмнөх оноосоо бууралттай гарч байгаа.





Салбаруудын 2024 оны VIII сарын шинжилгээний ажлын дүн

2024-09-12

| д/д | Салбарын нэрс | Бэлчээр ХД-1, 1а | | | | Хортон ХД-7а,б | | | | Дундаж | Байр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | м/х | х/б | д/м/ч | д/м/б | м/х | х/б | д/м/ч | д/м/б | | |
| 1 | Ховд | 100 | 100 | 96.0 | 89.2 | 100 | 100 | 100 | 100 | 98.15 | VI |
| 2 | Булган | 100 | 100 | 93.0 | 93.9 | 100 | 100 | 99.5 | 100 | 98.30 | V |
| 3 | Зэрэг | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | I |
| 4 | Мөнххайрхан | 100 | 100 | 99.5 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 99.94 | II |
| 5 | Чандмань | 100 | 100 | 98.0 | 92.8 | 100 | 100 | 93.5 | 100 | 98.04 | VII |
| 6 | Мөст | 100 | 100 | 96.0 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 99.50 | III |
| 7 | Манхан | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | I |
| 8 | Цэцэг | 100 | 100 | 97.0 | 65.7 | 100 | 100 | 98.0 | 100 | 97.59 | VIII |
| 9 | Дунд-ус | 100 | 100 | 99.0 | 92.8 | 100 | 100 | 100 | 100 | 98.98 | IV |
| 10 | Алтай | 100 | 100 | 99.0 | 84.7 | 100 | 100 | 99.5 | 100 | 97.84 | 8 |
| 11 | Дарви | 100 | 100 | 98.0 | 92.8 | 100 | 100 | 100 | 100 | 98.85 | 2 |
| 12 | Дуут | 100 | 100 | 85.0 | 91.8 | 100 | 100 | 96.0 | 100 | 96.60 | 6 |
| 13 | Дөргөн | 100 | 100 | 98.0 | 97.0 | 100 | 100 | 96.0 | 100 | 98.88 | 1 |
| 14 | Мянгад | 100 | 100 | 98.0 | 89.8 | 100 | 100 | 97.0 | 100 | 98.10 | 4 |
| 15 | Үенч | 100 | 100 | 99.0 | 92.8 | 100 | 100 | 98.0 | 100 | 98.72 | 3 |
| 16 | Эрдэнэбүрэн | 100 | 100 | 96.0 | 78.6 | 96.0 | 100 | 100 | 100 | 96.32 | 7 |



*Зураг.Салбаруудын тайланд шалгалт хийж дүгнэж, хариу зааварчилгаа бичсэн байдал*

Төвийн ХААЦУСХ-с сар бүрийн /IV-IX/ бэлчээрийн ургамлын үзэгдэлзүйн болон 2023 оны БТБ-ын *шүүмж шалгалтын хариу зааварчилгааг авч ажилласан.*

ХААЦУ-ын сангийн баяжилтыг 10 хоног бүрийн Агро мэдээгээр үүссэгдэж байгаа тул салбаруудаас дамжуулж байгаа мэдээний чанарт тогтмол хяналт тавьж ажилласан. ХААЦУСХ-н аймаг хариуцсан инженерүүд мөн 10 хоног бүр аймгийн ХААЦУ-ын салбарын ажлыг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгч 10 хоног бүр хариу зааварчилгаа ирүүлдэг болсон.












*Зураг. Агро мэдээгээр сан үүсэж, шалгалт хийгдсэн байдал*

| № | Салбарын нэрс | Х/Б | Т/И | А/М/Б | А/М/Ч | ерөнхий дүн | байр |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ховд | 100 | 100 | 97.2 | 99.2 | **99.1** | **V** |
| 2 | Мөнххайрхан | 100 | 100 | 99.2 | 99.9 | **99.8** | **II** |
| 3 | Зэрэг | 100 | 100 | 99.4 | 99.4 | **99.7** | **III** |
| 4 | Байтаг | 100 | 100 | 98.3 | 99.3 | **99.4** | **IV** |
| 5 | мөст | 100 | 100 | 97.2 | 99.1 | **99.1** | **V** |
| 6 | Чандмань | 100 | 100 | 97.2 | 98.0 | **98.8** | **VI** |
| 7 | Цэцэг | 100 | 100 | 93.9 | 99.0 | **98.2** | **VIII** |
| 8 | Манхан | 100 | 100 | 99.7 | 99.7 | **99.9** | **I** |
| 9 | Дунд-Ус | 100 | 100 | 95.2 | 99.6 | **98.7** | **VII** |
| 1 | Алтай | 100 | 100 | 93.1 | 98.1 | **97.8** | **VI** |
| 2 | Дарви | 100 | 100 | 98.3 | 99.7 | **99.5** | **I** |
| 3 | Дуут | 100 | 100 | 96.4 | 97.5 | **98.5** | **IV** |
| 4 | Мянгад | 100 | 100 | 98.6 | 98.7 | **99.3** | **II** |
| 5 | Үенч | 100 | 100 | 97.4 | 99.3 | **99.2** | **III** |
| 6 | Эрдэнэбүрэн | 100 | 99.7 | 93.7 | 98.7 | **98.0** | **V** |
| 7 | Дөргөн | 100 | 100 | 97.5 | 99.3 | **99.2** | **III** |

**Мэдээлэл үйлчилгээний ажлаар:** ХААЦУ-ын салбараас өнгөрсөн цаг агаарын нөхцөлийн тойм зөвлөмж мэдээгээр үйлчилж ажилладаг. 2024 оны байдлаар 10 хоногийн мэдээгээр 36, сарын 12, улирлын 3, жилийн 1, цаг үе хүндэрсэн үеийн болон шаардлагатай тойм зөвлөмж мэдээ, мал өвөл, хаврын 2024-2025 оны бэлчээрийн даацын мэдээг гаргаж нийт 52 тойм зөвлөмж мэдээ салбараас гаргаж мэдээллээ байгууллагын болон сум, багийн пэйж хуудсанд баршуулан малчид, ард иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилж ажилласан.





*Зураг. Байгууллагын пэйж хуудсанд мэдээлэл байршуулсан байдал*

### 4.3. Ус судлалын шинжилгээний ажлын талаар:

Хөдөөгийн харъяа салбаруудаас ирсэн тайлан материалд техник болон шүүмж шалгалт хийж,харилцах дэвтэр хөтлөн,сар бүрийн 20-нд харъяа салбаруудад хүргүүлж ажиллаж байсан. Шаардлагатай үед заавар, зөвлөмжийг утсаар өгч байсан. Мөн УХ-2А,УХШ-1 хүснэгтэнд шивж,хөндлөн огтлолын зураглал хийж,сар бүрийн 20-нд Гадаргын судалгааны хэлтэст сүлжээгээр дамжуулж байсан.

2023 оны УД-1,УД-2 дэвтрийг ,,Реки-Режим,, программд шивж, жилийн урсацыг бодуулсан. Мөс цөмрөх аюулаас сэрэмжлүүлэх мэдээ болон үер усны усны сэрэмжлүүлэх мэдээг нийт 23 удаа, ,,Масс мессеж” –ээр 2 удаа зохион өгч, вэбээр болон аймаг орон нутагт үйлчилж байсан.




*Зураг1.Усны сэрэмжлүүлэг мэдээгээр үйлчилсэн байдал.*

Ус судлалын Ховд өртөөний Буянт-Ховд, Бодонч-Алтай, Үенч-Үенч,Чоно-Харайх-Дөргөн,Хар-Ус-Дөргөн,Ховд-Мянгад,Улаан ам-Эрдэнэбүрэн,Төгрөг-Манхан,Дундцэнхэр-Мөнххайрхан,Долооннуур-Мөнххайрхан,Булган-Байтаг зэрэг бүх харуулуудад ШТА хийж, шонгийн засвар гаргах, хөндлөн зүсэлт хийх, дотоод ажилтай нь танилцах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Уршуулалтын ГГИ-3000 багажийг 2024 оны 04-р сарын 29-нд Ховд өртөөний техникч нартай хамтран суулгаж, ажиглалтанд бэлэн болгосон.Мөн 10-р сарын 01-нд багажуудаа хураан авч, ажиглалтыг зогсоосон.



*Зураг-2. Уршуулалтын ГГИ-3000 багаж суурилуулсан байдал.*

Буянт голын ус судлалын ажиглалтын цэг дээр гулдрилын хэмжилтийг 05,09-р саруудад 2 удаа хийж зураглал үйлдэж, төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлж ажилласан.




*Зураг-3.Буянт-Ховд ус судлалын харуулын хэв гульдрилын зураглал хийсэн байдал.*

УС СУДЛАЛЫН САЛБАРУУДЫН 2024 ОНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДҮН

Ховд аймгийн УЦУОШТ-ийн Гадаргын усны 10 харуулыг 2024 оны 05-р сард YAMAHA брендийн мотоциклээр хангасан. Буянт-Ховд ус судлалын харуулыг түр харуулын цэг дээр 06-р сард ЦУОШГазрын даргын шийдвэрээр нүүлгэн шилжүүлэх,тохижуулах ажлыг 100% хэрэгжүүлэн ажиллаж, цаашид шинжилгээний ажил хийхэд асуудалгүй болгосон.










*Зураг. Харуулуудыг унаагаар хангасан, Буянт-Ховд харуул нүүлгэж, тохижуулсан нь*

Орон нутгийн салбаруудын шинжилгээний хөтөлбөрт ажил хэвийн явагдаж ирсэн. 2023 оны урсацыг бодож, 2024 оны 04-р сарын 01-нд төвд хугацаанд нь хүргүүлж ажилласан. Харъяа 11 салбараас усны түвшин булингарын ажиглалтын мэдээ, өнгөрөлтийг хүлээн авч шүүмж шалгалт хийж тогтоосон хугацаанд төвд хүргүүлсэн.

2024 оны байдлаар:

| д/д | Харуулын нэр | Т/и | М/б | Т/б | А/ч | Биологийн сорьцын дүн | Тогтмол мэдээний дүн | Химийн сорьцын дүн | Дүн | Байр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Буянт-Ховд | 100 | 98,7 | 100 | 99,9 | 100 | 100 | - | 99,76 | I |
| 2 | Төгрөг-манхан | 100 | 99,1 | 100 | 99,2 | 99.0 | 100 | 100 | 99.6 | II |
| 3 | Бодонч-Алтай | 100 | 97,2 | 100 | 99,5 | 100 | 100 | 100 | 99.52 | III |
| 4 | Чоно -Харайх | 99,9 | 97,3 | 100 | 99,8 | 100 | 100 | - | 99,5 | IV |
| 5 | Ховд-Мянгад | 100 | 98,3 | 100 | 99,7 | 100 | 96.7 | 100 | 99.24 | V |
| 6 | Долооннуур-Мөнххайрхан | 98,3 | 98,1 | 100 | 99,1 | 97.0 | 100 | 100 | 98.92 | VI |
| 7 | Улаан ам-Эрдэнэбүрэн | 100 | 99,4 | 100 | 98,1 | 97.0 | - | - | 98.9 | VII |
| 8 | Үенч-Үенч | 100 | 95,4 | 100 | 99,5 | 100 | 96.7 | 100 | 98.8 | VIII |
| 9 | Дундцэнхэр-Мөнххайрхан | 100 | 99,5 | 100 | 99,0 | 98.0 | 93.4 | 100 | 98.55 | IX |
| 10 | Булган-Байтаг | 100 | 92,3 | 100 | 98,9 | 100 | 93.4 | 100 | 97.8 | X |
| 11 | Хар-Ус Дөргөн | 99,6 | 94,9 | 100 | 99,1 | 92.0 | 86.8 | 99.2 | 95.94 | XI |
| 12 | **Ус судлалын Ховд өртөө** | 99.8 | 97.3 | 100 | 99.2 | 98.4 | 96.7 | 99.9 | 98.8 | |

Салбаруудын дүнгээс харахад 2024 оны шинжилгээний ажлаараа манлайлан ажилласан салбарууд:

1. Буянт-Ховд 99.76%
2. Төгрөг-Манхан 99.60%
3. Бодонч -Алтай 99.52%-тай

Өнгөрөлт хэмжилт: Энэ онд хэмжвэл зохих 560 өнгөрөлт хэмжихээс хэмжсэн нь 560 болж, 100%-тай байна. Төлөвлөгөөт өнгөрөлт бүрэн хийгдсэн байна.

Хими болон биологийн сорьц: Усны химийн сорьцын хувьд 49 сорьц ирэхээс 49 ирсэн байна. Биологийн сорьцны хувьд 05-р сараас биологийн сорьцыг явуулж эхэлсэн. Усны биологийн 05-09 сарын хооронд 55 ширхэг сорьцыг төлөвлөгөөний дагуу хүлээн авч, төвд цаг хугацаанд нь явуулсан.

**4.4.Мөстөл судлалын шинжилгээний ажлын талаар**

Мөстөл судлалын харъяа Улаан-ам- Эрдэнэбүрэн ус зүйн харуулын ажиглагч Я.Батгэрэл, Мөстөл судлалын өртөөний технигч Я.Батцэнгэл, Долооннуур-Мөнххайрхан ус судлалын харуулын ажиглагч Д.Сонинболд нарт МӨСТӨЛ, МӨСӨН ГОЛД АЖИЛЛАХ ҮЕИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ-ийг танилцуулж хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар зааварчлага өгч ажиллаж байна. 2024 оны Мөстөл судлалын шинжилгээний хөтөлбөрт ажил эхлэхтэй холбогдон бэлтгэл ажлаа бүрэн хангаж ажилласан бөгөөд хяналт шалгалтын ажлаар төвийн мөстөл судлалын инженер Т.Хашэрдэнэ, техникч Я.Батцэнгэл, УЦУОСМХ-ийн ГУСХ-ийн инженер Х.Пүрэвдагва нар 8 дугаар сарын 14-15-ны хооронд Цамбагарав уулын судалгааны хавтгайд ажиллаж, багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хавтгайд байрлуулсан шонгийн байрлал зэргийг шалгаж, автомат станцын тоололт авч ажилласан.

Мөстөл судлалын шонгийн тоололт авах ажил 6 дугаар сарын I 10 хоногоос 10 хоног бүр авч мэдээллээ салбарын техникч авч төвийн инженерт тогтмол мэдээлж ажилласан.






*Зураг. Цас, мөсний хэмжилт хийж байгаа болон хайлалтын сүүлийн 3 жилийн явц харуулсан график*

Цэвдэг судлалын 2 цэгийн 2023 оны мэдээг ГУССХ-т хүргүүлсэн. III улиралд багтаан хуулж авахаар төлөвлөн багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгаж, гэмтэлтэй төхөөрөмжийг шинээр сольж тавихаар бэлэн болгосон.








*Зураг. Цэвдэг судлалын болон мөстөл судлалд ашиглаж байгаа багажуудаас мэдээлэл хуулж авч байгаа нь*

Цэвдэг судлалын 2 цэгийн мэдээллийг 2024 оноос жилд 1 удаа хуулж авахаар ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Наранхайрханы энгэрт байрлах цэгийн мэдээг 2024.10.11, Цэцэг нуурын хөвөөнд байрлах цэгээс 2024.07.19 хуулж авсан ба шаардлагтай засвар үйлчилгээ хийж батерей сольсон. уулын энгэрт байрлуулж 3 метрийн гүнд гүн дэх багажийн тоолoлтыг хавар, намар 4 удаа авсан.

***4.5.Байгаль орчны шинжилгээний лабораторийн ажлын талаар:***

Хөтөлбөрийн дагуу гадаргын ус , агаар, хөрс, төв цэвэрлэх байгууламжийн бохир усны шинжилгээг тасралтгүй хийж гүйцэтгэж ажилласан.

Жилд шинжилгээ хийхэд хэрэглэгдэх бүх урвалж уусмалыг улирал бүр бэлтгэхэд хяналт тавьж, төв лабораторийн инженерт хянуулсан.

Нэрмэл ус нэрж шинжилгээний урвалж уусмал бэлтгэх, шинжилгээ хийх, багаж тоног төхөөрөмжинд цэвэрлэгээ үйлчилгээ хийхэд ашиглаж байна.

***Чанарын хяналтын талаар:*** БОХЗТЛабораториос ирүүлсэн зааварчилгаа зөвлөмж аргачлалын дагуу эрхлэгч, инженерүүд гадаад чанарын хяналтын ур чадварт $NO_2$, $SO_2$, 2 удаа / 7 сар, 11 сард/ Усны гадаад чанарын хяналтын ур чадварт гол ион болон биогенээр 7 сар 11 сард 2 удаа, хөрсний гадаад чанарын хяналтын ур чадварт 7 сард 1 удаа оролцсон.

Хяналтын дээжийг 2024 онд Буянт- дээд, Буянт-доод цэгээс зэрэгцээ 5, 9 саруудад авч шинжилгээ хийж өөрийн лабораторийн урвалж уусмалын чанар, шинжилгээний ажлын ур чадварыг шалгах зорилгоор БОХЗТЛ-той харьцуулан хийсэн.

***Гадаргын усны шинжилгээний ажил:*** Ховд аймгийн нутагт урсаж буй 9 гол /Буянт-дээд, Буянт-доод, Ховд-Мянгад, Булган-Байтаг, Мөнххайрхан-Долоон нуур, Төгрөг-Манхан, Мөнххайрхан - Дундцэнхэр, Алтай – Бодонч, Үенч - Үенч, Дөргөн-Чонохарайх дээд, доод,/ 1 нуурын /Дөргөн Хар ус/ уснаас дээж авч нийт 60 дээжинд химийн задлан шинжилгээг гол ион, биогены элементүүдээр нийт 1200 үзүүлэлтээр шинжилгээ хийж бохирдлын хэмжээг тодорхойлсон. Буянт голын доод цэгээс хөтөлбөрийн дагуу 3 сард дээж авахаар байсан боловч голын ус хөлдүү учир дээж авч чадаагүй тул зургийн авч баримтжуулан албан бичгийн хамт төв лабораторид хүргүүлсэн.

Шинжилгээний дүнгээс харахад голуудын усны бохирдол хүлцэх агууламжаас давж бохирдсон үзүүлэлт ажиглагдаагүй байна.

Төв цэвэрлэх байгууламжийн орох, гарах цэгээс сар бүр усны сорьц авч шинжилгээг 24 дээжинд 4-9 үзүүлэлтээр нийт 156 удаа хийсэн. Бохир усны цэвэршилтийн дүнгээс харахад ц эвэрлэгээний чанар нь 42.3 - 68% байсан байна.

***Агаарын шинжилгээний ажил:*** Жаргалант суманд суурин цэгээс агаарын дээжийг агаар дахь хүхэрлэг хийн болон азотын давхар исэл тус бүр 650 удаа тоосны сорьцыг 365 удаа авч нийт 1665 удаа авч шинжилгээ хийж өдөр бүрийн шинжилгээний дүнг боловсруулан дэвтэр, хүснэгтийг хөтлөж ажилласан.







*Зураг. Агаарын чанарыг сүүлийн 4 жилийн харуулсан график*

Азотын давхар исэл, хүхрийн давхар ислийн хэмжээ MNS4585:2016 стандарт хэмжээнээс давсан үзүүлэлт ажиглагдаагүй байна.

Агаар дахь PM2.5 тоонцорыны агууламжийг хөтөлбөрийн дагуу өдөр бүр 24 цагаар нийт 365 удаа ажиглалт хийсэн. MNS4585:2016 стандарт хэмжээнээс хархад хүйтний улиралд нийт 119 удаа давсан үзүүлэлт ажиглагдсан байна.




*Зураг. Сүүлийн 3 жилийн агаар дахь PM2.5 тоосны бохирдол харуулсан график*

Агаар дахь PM2.5 тоосонцорын сүүлийн 3 жилийн дүнг MNS4585:2016 стандарт хэмжээтэй харьцуулж үзэхэд 0.2 - 5.6 %-иар давсан байна.

***Цацрагийн түвшний ажиглалт***: Цацрагийн түвшний ажиглалтыг Ховд өртөөнд агаар хөрсөнд нийт 1432 удаа ажиглалт хийсэн.

Ховд өртөөний цацрагийн түвшний ажиглалтын дүнгээс харахад энэ жил хамгийн их тун агаарт 0.15 мкзв/цаг, хөрсөнд 0.16 мкзв/цаг тунгийн бохирдолтой гарсан байгаа нь байгалийн фоноос давсан бохирдол ажиглагдаагүй.

Булган-Байтаг өртөөнд агаар хөрсөнд нийт 1428 удаа ажиглалтыг хийж мэдээг дамжуулсан.

Булган-Байтаг өртөөний цацрагийн түвшний ажиглалтаас харахад хамгийн их тун агаарт 0.15 мкзв/цаг, хөрсөнд 0.16 мкзв/цаг тунгийн бохирдолтой гарсан байгаа нь байгалийн фоноос давсан бохирдол ажиглагдаагүй.

Мөн Цөмийн энергийн газарт 2 станцын цацрагын RDS-110, AT6130 багажуудыг 04 сарын 20-с 04 сарын 30-ний хооронд баталгаажуултанд оруулсан.

***Хөрсний шинжилгээний ажил:*** Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 145 тоот тушаал, хөтөлбөрийн дагуу энэ онд аймгийн төвийн нийт 15 цэгээс хөрсний дээж авч агрохимийн шинжилгээг орон нутагт, хүнд метал тодорхойлох дээж, агрохимийн шинжилгээний үр дүнг төв лабораторид хүргүүлсэн.

***Орчны бохирдлын мэдээгээр үйлчилсэн:***

www.Khovd.tsag-agaar.gov.mn сайт, 192.168.100.13 агаарын мэдээг өдөр бүр буюу 1665, гадаргын усны мэдээг сар бүр буюу 12, бохир усны мэдээг сар бүр буюу 12, хөрсний мэдээг 1 удаа

Ховд ус цаг уур facebook агаарын мэдээг өдөр бүр

eic.mn/radiation/index.php - Цацрагийн мэдээг өдөр бүр 2860 мэдээг байршуулахад хяналт тавиж ажилласан.








Тухайн салбарт 2024 онд инженер, техникч нарын буруугаас тасарсан болон хугацаа хоцорсон мэдээ, тайлан байхгүй.

***Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлсэн ажлын талаар:***

Аймгаас захиалга өгсөн, гэрээтэй аж ахуй нэгж байгууллага, ард иргэдийн хүсэлтээр агаар, ус, хөрсний шинжилгээ хийж тайлан мэдээ мэдээллийг бүрэн гаргаж өгсөн.

Байгаль Орчин Аялал Жуулчлалын сайдын 2018 оны 11 сарын 30 өдрийн А-479 тоот журмын дагуу Аймгийн Засаг даргын 2023 оны 11 сарын 27 өдрийн А/739 тоот захирамжаар байгуулсан ажлын хэсгийг бүрэлдэхүүн нь Ховд аймгийн хэмжээнд агаар бохирдуулж байгаа эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн тооллогыг 2023 оны 12 сарын 01-нээс 2024 оны 02 дүгээр сарын 05-ний хооронд зохион байгуулж, дүнг нэгтгэн цахим санд бүртгэх ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Аймгийн засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь хяналтын тооллогын үйл ажиллагааны зардалд 3.736.800 төгрөгийн санхүүгийн зардлыг орон нутгаас шийдвэрлүүлж “Буянт, Мянгад, Дөргөн, Манхан, Зэрэг, Чандмань, Дарви, Цэцэг, Булган, Үенч, Алтай” гэсэн 11 сумдад ажиллаж, тухайн сумын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд арга зүйн зөвлөгөөг өгч хяналтын тооллогыг хамтран хийсэн.



*Зураг.Аймгийн агаарын бохирдлын тооллогоны ажлаар*

Энэ онд тусгай захиалгатаар байгуулагын төсвөөс гаднах орлого нэмэгдүүлэх зорилгоор хөтөлбөрт бус шинжилгээг хийж 2.3 сая төгрөгний орлогыг байгууллагад оруулж ажиллалаа. Мөн Стандарт шаардлагад нийцсэн индукцийн плитк, татах шүүгээнд хүчил, шүлт тавих тавиур хийлгэсэн.









*Хөтөлбөрт бус ажил татах шүүгээнд хүчил, шүлт тавих тавиур*

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хөрсний бохирдлын байнгийн мониторингийн цэгийг бий болгох, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор аймаг төвийн 40 цэгээс хөрсний дээж авч хүнд металийн дээж бэлдэж төвд хүргүүлсэн, агрохимийн шинжилгээ

хийж дүнг хугацаанд нь хүргүүлсэн. Мөн БОУАӨЯамний харьяа Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу уур амьсгал эрчимтэй явагдаж байгаа Ховд сумын бэлчээр нутгаас хөрсний дээжийг 50*50 хэмжээтэй нүх ухаж хөрсний дээжийг 0-30 см, 30-50 см гүнээс дээж авч БОУАӨЯаманд хүргүүлсэн.



*Зураг. Хөрсний дээж авах цэгийг сонгож дээж авч байгаа нь*

БОШЛ-ийн инженерүүд Ундны усны талаархˮ сургалт инженерүүд, ус судлалын техникч нар сууж мэдээлэл хийсэн. Аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал сургалт 11-р сарын 07 нд суусан. Монгол улсын "Гавьяат багш", МУИС-ийн "Хүндэт профессор", С. Дондогийн "Гетрополийн хүчлүүдийн химийн судалгааˮ, **“Ус элемент биш** харин нэгдэл юм**ˮ** сэдэвт онлайн сургалтанд хамрагдсан. БОАЖЯамнаас зохион байгуулсан “Агаар чанарын хяналтын нэгдсэн систем Монголдˮ сургалтанд БНСУ-д оролцож туршлаг судалсан.




*Зураг. Сургалтанд суусан нь*

**4.6. Багажийн баталгаажуулалт, шалгалт тохируулгын ажлын талаар:**

Хэмжил зүйн эрхэм зорилт: Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, хэмжих хэрэгслийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах.

Зорилтууд: Хэмжил зүйн ажлын чанарыг сайжруулах, Багаж тоног төхөөрөмж, тавил тохируулгаас шалтгаалсан хэмжил тасралтгүй байх, Багаж тоног төхөөрөмжид гэмтэл гарсан тохиолдолд аль болох богино хугацаанд инженертэй холбогдож гэмтэл илрүүлэх засварлах улмаар мэдээ мэдээллийн тасралт маш бага байхаар ажлаа төлөвлөж зохион байгуулж ажиллаа. Үүний үр дүнд автомат станц багаж тоног төхөөрөмжөөс шалтгаалсан мэдээллийн тасралт тасралт гаргалгүй ажилласан.

. Автомат станцуудын 1 минут 5 минутын мэдээлэлд байнга хяналт тавьж ажилласнаар багаж
тоног төхөөрөмж байнгын хяналтад байсан учир гэмтэл саатал маш бага гарсан.

· Байгууллагын хэмжих хэрэгслийг шалгалт тохируулга, төлөвлөгөөний дагуу 9 өртөө, 7 харуул, ус судлалын 11 харуулын багаж тоног төхөөрөмжийг баталгаажуулалтад хамруулах

. Шалган туслах ажлаар төлөвлөсөн салбаруудаар тойрч автомат станц, багажийн үйлчилгээг бүрэн хийх. Багаж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах.

Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын болон шалгалт тохируулгын график, төлөвлөгөөг гарган БОХЗТЛ-ийн болон УЦУОШТ-ын даргаар батлуулан мөрдөн ажилласан. УЦУОШТ-өөс 2024 онд өртөө, харуулуудын ажилд ашиглагдаж буй хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах, үзлэг үйлчилгээг тогтмолжуулах шаардлага хангасан хэмжих хэрэгслээр ажиглалт хэмжилтийг үнэн зөв хийлгүүлэхэд ажлаа чиглүүлж ажиллав. Багаж хэмжих хэрэгсэл болон материалын захиалгыг ЦУОШГазарт явуулж, хангалтаар ирсэн 10 ш UPS-н батерей, bttry charger 1ш, агаарын чийгийн мэдрэгч, агаарын чийг температурын мэдрүүрийн шүүлтүүр, чернил,ХАА-н цахилгаан жин, метр тус бүр 2ш, орон нутгийн хөрөнгө оруулалт техникчдийн оролцоотойгоор 56 төрлийн 12854 ш материалуудыг салбаруудад хуваарилан өгч хэмжлийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллаа. Шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн судалгааг тухай бүр гаргаж холбогдох газруудад нь хүсэлт явуулж шийдвэрлүүлж ажиллаа.

***Багажийн ашиглалт, хамгаалалт, хэмжих хэрэгсэлд хийсэн үзлэг, шалгалт, шинээр суурилуулсан багаж, тохируулгын талаар:***

Энэ онд шалган туслах ажлын графикийн дагуу 9 өртөө 7 харуулд шалган туслах ажил хийж, 9 өртөөний автомат станцад үзлэг үйлчилгээ хийж, AWS 310 станц 5, AWS 330 загварын автомат станц 3, CAMS620 автомат станцуудад цагны тохиргоо, программын тавил тохируулгууд хийж, баталгаажуулах тоолопт БОХЗТЛабораторийн Улсын шалгагчид шалгуулж, багаж баталгаажуулалтсан гэрчилгээ авч ажилласан.

Шалгалт тохируулгын эталон багажууд чийг температурын HMP46 маркийн, k0750009 серийн дугаартай, агаарын даралтын PTB 220 маркийн X1950011 серийн дугаартай эталон багажуудыг шалгалтад оруулж, баталгаажуулалтын гэрчилгээнүүд авч ажиллаа.



*Зураг. Чийг температур, даралтын багажийн баталгаажуулалтын гэрчилгээ*



*Зураг. Бүх өртөөний автомат станцууд бүрэн баталгаажуулалтад хамрагдаж гэрчилгээ авсан.*









*Зураг. Автомат станцын хяналт баталгаажуулалтын тоололт авсан байдал агаарын температур , чийг, даралтын багажийг нэг орчинд байрлуулж тоололт авч байгаа нь.*
Цаг уурын харуулуудад HUYAUN автомат багажын логерийг тусдаа цоожтой төмөр хайрцагт байрлуулж, мэдрүүрийг стандартын шаардлага хангасан тусдаа суурь хийж байрлуулж ажиглалт хийж байна.



*Зураг. 7 харуулд бүгдэд нь Харуулын логерийн хайрцаг, мэдрүүрийг байрлуулсан байдал.*

Мөст өртөөний AWS - 330 автомат станцын чийгийн мэдээлэл тасарсан гэж 04 сарын 22 ны өдөр дуудлага ирсэн тухайн үед anydesk- ээр шалгалт хийж үзэхэд агаарын чийгүүд орж ирэхгүй, логероос мэдээлэл ирэхгүй байсан ба газар дээр нь очиж шалгаж үзэхэд холбогч кабелд гэмтэл гарсан, бүх кабелийг гагнаж битүүмжлэл сайжруулж хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн 2024 оны 3 р сарын 12 нд н автомат станц ямар ч мэдээлэлгүй болсон логер ажиллахгүй байсан шалгаж үзэхэд btry charger шатсан байсан btry charger ЦУОШГ-т хүсэлт тавьж шийдвэрлүүлж суурилуулснаар автомат станц хэвийн ажиллагаанд орсон.



*Зураг . Батарей charger сольсон*

ЦУОШГазарт автомат станцуудын UPS үүд ажлын шаардлага хангахгүй болсон шийдвэрлэж өгөх хүсэлт явуулж, 10 ш батарей, 50метрийн урттай метр 2ш, электрон жин 2ш, тунадас хэмжүүрийн аяга 16 ш олгосон, тус багажуудыг шаардлагатай салбаруудад хувиарлаж тавьж өгсөн.






*Зураг. ЦУОШГ-аас олгосон багаж төхөөрөмж*



*Зураг. Зэрэг өртөөний CAMS-620 2024 оны 03 -р гэмтэл гарч ажиллахгүй болсон. Логерийг төвд авч ирж засварлаж хэвийн ажиллуулж байна , 4-н салбарын цагийн*

*механизмын бохирдол, өвлийн улиралд царцсан гацсан гэмтлийг W-40 бодисоор цэвэрлэж шалгаж байрлуулсан хэвийн ажиллаж байна.*

Цаг уурын харуулуудад HUAYUN агаарын чийг температур, хөрсний температурын мэдрүүр бүхий төхөөрөмжөөр бүрэн хангасан. Шалган туслах ажлаар явахдаа төхөөрөмжийн цаг тааруулсан. Эрдэнэбүрэн Алтай сумдын мэдрүүр гэмтэл гарсан сольж хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна.





*Зураг. Мөнххайрхан өртөөний автомат станц дээр сургалт дадлага хийсэн нь.*

Энэ жил ЦУОШГазраас термометрийн хангалт хийгдээгүй, Ус судлалын Булган - Байтаг харуулд усны температур хэмжих бортогот термометрийг дүүгүүр термометр, витамины сав зэргийг ашиглан хийж, ус судлалын харуулд харьцуулсан тоололт хийж зөрөөгүй таарч байсан тул өгч тасралтгүй хэвийн ажиллагааг хангасан. Мөн вертушканы сигнал сонсогдохгүй байсан тул техникч Я. Батгэрэлийн хамт унадаг дугуйны сигнал хийж өгсөн.






*Зураг . Булган- Байтаг дүүгүүр термометрээр гадуур нь гэр хийж өгсөн. Хэмжилт хийж байгаа нь мөн вертушкэнд унадаг дугуйны сигнал гагнаж суурилуулж өгсөн* нь

Цасны жингийн 2 эмээл, нэг янгаа дутуу байсныг худалдан авч өөрөө хийж харьцуулан шалгаж хэвийн ажиллагааг хангалаа. Мөн Манхан өртөөний AWS330 автомат станцад логерийн мэдээллийг шууд дэлгэцэд харахаар MWS-1.0 DATALOGGER маркийн дэлгэц авч тавьсан одоогоор цахилгаан эрчим хүч тасарсан үед мэдээллийн тасралтгүй байдал хангаж сайн ажиллаж байна.






*Зураг. Цасны жингийн янгаа хийсэн, эмээл сэлбэсэн. MWS-1.0 дэлгэ1 минут, 5 минутын мэдээллүүдэд байнга хяналт тавьж тасралтгүй ажиллуулж байгаа нь*

Одоогоор тухайн өртөө бүр дээр админ эрх үүсгэж өөрснөө мэдээллээ ашиглах хяналт тавих тал дээр ажиллаж байна.




*Зураг. 1 минут, 5 минутын мэдээлэл дамжуулсан байдал*



*Зураг 12. Цагийн механизм засварлах үйлчилгээ хийх тохиргоо хийх, мөн цасны рейкийг гадаа зориулалтын хуулгаар хийж шинэчлэж өгсөн нь*

Станцын хурын хувин байнга цэвэрлэх мөн автомат станцын цэвэрлэгээ арчилгаа үйлчилгээний талаар зааварчлаг өгсөн. Автомат станцын цаг шалгаж хэвийн ажиллагааг шалгасан.

Цэцэг өртөөний AWS 310 автомат станцын логерийн дэлгэцийн залгуурын үүр 8 хөлтэй шон хугарсан гагнаж хэвийн ажиллагаанд оруулсан. Өвлийн улиралд -35 аас дээш гарч хүйтэрдэг тул аккумлятор дулааалахад залгуур хөшигдөж хугарсан байна.



*Зураг. Дэлгэцийн уян залгуурын хөл хугарсан засаж ажилд оруулсан нь.*

Бүх өртөөнд чернил, Мөст, Дунд ус үзэгний хошуу, ус судлалын харуулд шаардлагатай багажуудын хангалт хийж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллав.

Шаардлагатай тохиолдолд facebook chat аар зааварчлаг өгч ажиллаж байгаа. Сүүлийн үед интернэт сүлжээг үйл ажиллагаандаа өргөн ашиглах болсон. Одоогоор Anydesk Ultraviewer программаар орон нутагтай цаг алдалгүй холбогдож автомат станцын тасралтгүй ажиллагааг хангаж ажиллаж байна.

Цаг уурын өртөөдөд зориулж, станцын тавил тохируулга хэрхэн хийх талаар видео танилцуулга заавар хийж нийт салбаруудад салбаруудад хүргүүлсэн. Цаг уурын автомат станцын ажиллагааг хянаж, ultraviewer, anydesk-ээр бүх өртөөтэй холбогдож, автомат станцын тохируулгыг давхардсан тоогоор 15 удаа хийж өртөөний дарга нарыг тавил

тохируулгыг хийж сургаж ажиллаж байна. Мэдрүүрүүдийн ажиллагааг шалгах ажлыг өртөөний дарга нартай холбогдож асууж лавлах, асуусан зүйлд зөвлөмж өгч ажиллаа.




*Зураг. ultraviewer ээр холбогдож тохиргоо хийж, цаг шалгаж байгаа нь*

**Багаж тоног төхөөрөмжийн хангалт, ажиллагаа улирлын чанартай ажлууд:** Цаг уурын шинжилгээний ажилд хэрэглэгдэх 2024 оны цаасан материал татан авч хуваарилалт хийж орон нутагт хүргүүлсэн. Цасны байнгын рейк 3 ш, зөөврийн рейк 2 ш, Дунд ус өртөө, Дарви харуулд өшсөн. 7 харуулд батист, нэрмэл ус өгсөн.

Хөдөө аж ахуйн заавар ХАА салбарт, Шивэлтийн заавар 1ш, Материал боловсруулалтын заавар 1ш, шивэлтийн заавар 1ш, тус тус олгосон.

Ховд өртөөнд ууршуулагч ГГИ 3000 тохируулга хийж байрлуулан ажиглалт хийгдэж байна. Ууршуулагчийн минзурк хагарсан, 30 см3 зориулалтын минзурк олж өгсөн. Мөн Ховд өртөөнд хөрсний гүний ЕМ50 автомат багажаар ажиглалт хийж сар бүр мэдээллийг УЦУОШХүрээлэнд хүргүүлж байна. ЕМ50 30 см бичилт хийгдэхгүй тасарсан мэдрүүр гэмтэлтэй гэж оношлосон. ХААЦУ сектороос мэдрүүр авч хэвийн ажиллаж байна.

Мянгад цаг уурын харуулын талбайг орон нутгийн хөрөнгө оруулалтаар томруулж шинэчилж, 20х16 м стандартын хэмжээтэй болгож төхөөрөмжилснөөр бүх харуулууд стандартын шаардлага хангасан ажиглалтын талбайтай боллоо.

Автомат станцын тавил тохируулга, хэвийн ажиллагааг хангах үзлэг үйлчилгээний талаар онлайн хичээлийг 3 удаа хийж ажилласан.

2024 оны 5 р сард Мөнххайрхан өртөөнд салбарын нэгдсэн семинар хийж бүх харуул өртөөний ажиглагчдад механик болон автомат станцын хэвийн ажиллагааг хангах шалгах, хяналт ажиглалт хийх талаар хичээл дадлага үзүүлэн ажиглалт хийж мэдээлэл зааварчлаг өгч ажилласан. Орон нутагт өртөөний талбайд багаж тоног төхөөрөмж дээр сургалт хийсэн ач холбогдол өндөр байсан.





*Зураг. Мөнххайрхан цаг уурын өртөөнд хийсэн нэгдсэн сургалт*

### *4.7. Урьдчилан мэдээлэх салбарын шинжилгээний ажлын талаар:*

Хөтөлбөрт ажлыг бүрэн биелүүлж ажиллахын тулд ЦУОШГ-ын УМХ-ийн УМСектор, НЦУТ-өөс өгсөн заавар зөвлөмжтэй тухай бүр танилцаж аймаг орон нутгийн удирдлага, малчид ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад шаардлагатай мэдээ мэдээллээр үйлчилснээс гадна, ИНЕГ-тай хийсэн ерөнхий гэрээний дагуу аймгийн нутаг дэвгэрт нислэг үйлдэж буй дотоод, гадаадын агаарын хөлгүүдийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах

зорилгоор нислэгт холбогдолтой мэдээ мэдээллүүдийг цаг хугацаанд нь шуурхай дамжуулан ажилласан байна.

Энэ онд хоногийн болон хагас хоногийн урьдчилсан мэдээг Ховд хот орчмоор болон 16 сумын нутгаар тус бүр 365 удаа гаргаж khovd.tsag-agaar.gov.mn цахим хуудас, Ховд Ус, цаг уур орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудас, LED дэлгэцээр хэрэглэгчдэд хүргэж ажилласан ба мэдээний чанар НУМ-94.7 хувь, ХУМ-93.1 хувь, 5 хоногийн мэдээний чанар 89.1 хувьтай өмнөх оноос мэдээний чанар 0.9-1.4 хувиар буурсан байна. 12 сард ажиглагдсан орон нутгийн чанартай хялмаағ, 01 сард ажиглагдсан халуун хуурай салхины нөлөөгөөр агаарын температурыг урьдчилан мэдээлж чадаагүйгээс мэдээний чанар буурсан байна.



*Зураг. 1-5 хоногийн урьдчилсан мэдээг фэйсбүүк пэйжид байршуулсан*

УИХ-ын болон орон нутгийн сонгууль болсонтой холбогдуулан нэмэлтээр 17 сумын 1-5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээг гаргаж аймаг, сумын сонгуулийн хороод, онцгой байдлын газар, цагдаагийн газарт хүргүүлсэн. Мөн Үндэсний их баяр наадам, Галданбошигт хааны 380 жилийн ойн өдрүүдийн цаг агаарын урьдчилсан мэдээг гаргаж пэйж хуудсаар хүргэсний дээр баяр наадмын талбайд 3 цаг тутамд бодит мэдээг үзэлээр зарлуулж ажилласан.














*Зураг. Баяр наадмын өдрүүдийн цаг агаарын урьдчилсан мэдээ, анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээг гаргаж хүргэсэн байдал.*

Өнгөрсөн хоногт болон өнгөрсөн долоо хоногт цаг агаар ямар байсан тухай тойм мэдээлэл 365 болон 52 удаа, сарын урьдчилсан мэдээг 12 удаа, улирлын урьдчилсан мэдээг

7 удаа гаргаж khovd.tsag-agaar.gov.mn цахим хуудас, Ховд Ус, цаг уур орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудас болон албан тоотоор гаргаж сум орон нутгийн удирдлага ард иргэдэд мэдээлсэн.











*Зураг. 1, 7 хоногийн тойм төлөв, Сар, улирлын урьдчилсан мэдээг фэйсбүүк пэйжид байршуулсан байгаа нь*

Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг урьдчилан сэргийлэх мэдээг хүчтэй салхиар 5 удаа, шороон шуургаар 1 удаа, цочир хүйтрэлтээр 4 удаа, сэрэмжлүүлэг мэдээг их цасаар 1 удаа, хүчтэй салхиар 1 удаа, анхааруулга мэдээг 57 удаа тус тус гаргаж khovd.tsag-agaar.gov.mn болон alarm.tsag-agaar.gov.mn цахим хуудас, Ховд Ус, цаг уур орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудас, LED дэлгэцээр хэрэглэгчдэд хүргэж

мэдээний чанар 95.1 хувь, онч 95.8 хувьтай өмнөх онтой харьцуулахад таарцыг 5.1 хувиар, оньч 2.0 хувиар тус тус ахиулж ажилласан байна.



*Зураг. СМ, УСМ-г пэйж хуудас, цахим хуудсанд байршуулсан байгаа нь.*

Харъяа цаг уурын 9 өртөө, 7 харуулаас байгаль цаг уурын аюултай үзэгдлийн аюул агаар мэдээ /ААМО/-г 434 удаа, 10 хоног болон сарын климат мэдээг 432 удаа хүлээн авч хянан төвд дамжуулсан. Аюул, агаар мэдээний дамжуулалт 100 хувь, чанар 99.6 хувь, климат мэдээний дамжуулалт 100 хувь, чанар 100 хувьтай ажилласан ба өмнөх онтой харьцуулахад хэвийн ажилласан байна..

Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдах нөхцөл бүрдсэн үед орон нутгийн Ховд телевиз, МҮОНРТ, Монголын радио, Ховд.мн, Khovdnews.mn сайтад нийт 11 удаа мэдээллийг өгч ард иргэдийг аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлж ажилласан. 1,5,7 хоног, сар, улирлын урьдчилсан мэдээг Ховд ус цаг уур орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудас болон khovd.tsag-agaar.gov.mn сайтад байршуулж ард иргэдэд тогтмол мэдээлж ажилласан.



*Зураг. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийж буй нь*

Ой хээрийн хуурайшлын зэргийг 3 сарын 15-наас эхлэн өдөр бүр бодуулж жилийн хугацаанд 187 удаа хуурайшлын мэдээг гаргаж аймгийн ОБГ-т хүргүүлж пэйж хуудсанд байршуулж байна.







*Зураг. Пэйж хуудсаар хуурайшлын мэдээ хүргэж буй байдал*

**4.8. Нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын талаар:**

Энэ онд үндсэн 448, бэлтгэл 728 нислэгийг бодит ажиглалтын METAR 3485, SPECI 179, урьдчилсан TAF мэдээ 1334, чиглэлийн УМ 224, районы УМ 349, аэродромын УМ 338, ХУМ 301, Угталтын УМ 17, Суултын УМ 1, Агаарын хөлгийн ажиглалтын мэдээ 2, харьцуулсан ажиглалт 12, 7 хоногийн төлөв 52 удаа гаргаж урьдчилсан мэдээний таарц 98.8, мэдээ зохиолтын чанар 94.7 хувьтай ажилласан. Буудал орчмын урьдчилсан мэдээний таарц зорилтот түвшнээс 0.06 хувиар ахисан. Мэдээ зохиолтын чанар өмнөх онтой харьцуулахад 4.05 хувиар буурсан байна.

Сар бүрийн 15, 25 болон цаг агаарын эрс өөрчлөлттэй үед Ховд олон улсын нисэх буудал болон Ховд УЦУОШТ-ийн Ховд цаг уурын өртөөний цаг уурын автомат станцын харьцуулсан тоололтыг 24 удаа хийж үр дүнг НЦУТ-д хүргүүлсний дээр харьцуулсан тоололтын зөрүү нь “Чикагогийн Конвенцын Хавсралт 3-ын Attachnment A"-д нийцэж байгаа талаар судалгаа гаргаж байна.

Хур тунадас, хүчтэй салхи, орон нутгийн чанартай нуурын манангийн судалгааны ажил хийгдэж байна.

Цаг агаар, орчны аюултай, гамшигт үзэгдэл ажиглагдах тохиолдолд анхааруулга мэдээг 57 удаа, урьдчилан сэргийлэх мэдээг хүчтэй салхиар 5 удаа, шороон шуургаар 1 удаа, цочир хүйтрэлтээр 4 удаа, сэрэмжлүүлэг мэдээг их цасаар 1 удаа, хүчтэй салхиар 1 удаа тус тус гаргаж багц мессэж үйлчилгээг ашиглан 10000 гаруй хэрэглэгчдэд 100% хүргэсэн. Өвөлжилт хаваржилт хүндэрсэн сумдын болон отроор өвөлжиж буй малчдын судалгааг нэмэлтээр гаргаж мэдээ мэдээллийг Багц мессэж үйлчилгээг ашиглан гар утсанд нь тогтмол хүргэж ажилласан. Аймгийн онцгой комиссын шийдвэрээр засаг даргын нөөц хөрөнгөөс 3000000 төгрөгийг шийдвэрлүүлэн Масс мессеж үйлчилгээг 4500 иргэний гар утсанд жилийн хугацаанд 69 удаа масс хүргэж урьдчилан сэрэмжлүүлсэн.




*Зураг. Багц мэссэж үйлчилгээгээр мэдээлэл хүргэсэн байдал, утасны жагсаалт*

Манай УМС-ын инженерүүдээс 2024 онд Нислэгийн цаг уурын төвөөс зохион байгуулсан орон нутгийн синоптик инженерүүдийн давтан сургалтанд төвийн 1 инженер хамрагдсан.



*Зураг. Сургалтанд оролцсон инженер*

Мэргэжлийн 3-р зэргийн шалгалтанд УМС-ын 3 инженер хамрагдснаас 2 инженер тэнцэж мэргэжлийн зэргийн нэмэгдэл аваад ажиллаж байна.

УМ-лэх ажлын дүнгээр сүлжээний хэмжээнд 8-р байранд, Нислэгийн цаг уурын үйлчилгээний дүнгээр улсад 1-р байранд орсон амжилттайгаар 2024 онд ажиллалаа.

### 4.9. *Сүлжээ ашиглалт болон мэдээ дамжуулалтын талаар:*

Сүлжээгээр мэдээлэл солилцох ажлын шуурхай тасралтгүй байдлыг хангахын тулд тоног төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавьж компьютерын техник хангамж болон программ хангамжийн системд гарах саатал, зөрчлийг шуурхай засаж арилган, сүлжээний үйл ажиллагааг 100% хүргэж ажиллалаа. Мөн шилэн кабелын хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавьж ажилласан бөгөөд энэ 2024 онд шилэн кабелийн гэмтэл, доголдол гараагүй. Цахилгаан тасарсан тухай бүрд нь мотор асааж хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

Ус, цаг уур, орчны ажиглалтын тогтмол мэдээнд хяналт тавих ажлын хувьд 2024 онд 9 өртөө, ХАА-н харуул, Ус судлалын 7 харуулын шуурхай мэдээний тасалдал хоцрогдолд хяналт тавьж ажиллалаа. Төлөвлөгөөт хөтөлбөрийн дагуу Ус, цаг уур орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих системээр 8 хугацааны синоптикийн мэдээ 26280 дамжихаас 26274 мэдээ дамжиж мэдээ дамжуулалт 99,6%-тай байна. Сар бүр шуурхай мэдээний тасалдал хоцрогдлын дүнг нэгтгэн өртөө харуулуудад хүргэж ажилласан. Энэ хугацаанд шуурхай мэдээний тасалдал хоцрогдол гаргахгүй байх талаарх заавар зөвлөмжийг амаар болон бичгээр байнга өгч ажилласан. 2024 оны хагас жилийн дүнтэй харьцуулахад 18-н мэдээгээр буурч мэдээ дамжуулалт-0,06%-иар өссөн үзүүлэлтэй байна. Сүлжээ ашиглалт 100% Мэдээ дамжуулалт 99.6% Нэгдсэн дүн 99.8% төвөөс нэгдсэн дүн ирээгүй.

2024 оны компьютерийн засвар үйлчилгээ хийх төлөвлөгөөт графикийн дагуу УМС, ЦАЗНЭ-н радарын инженер, Цаг уурын инженер техникч, ХАА-н инженер техникч, УСС-н харуулын ажиглагч, Дунд-Ус, Манхан, Чандмань, Мөст, Цэцэг, Зэрэг, Дарви, Дуут, Эрдэнэбүрэн харуул зэрэг нийт 48 компьютерт засвар үйлчилгээ хийж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа. Шинээр ашиглалтад орсон 28ш суурин болон зөөврийн компьютерт техник ашиглалтын паспорт хөтөлсөн.

ЦУОШГазраас 40 ширхэг лицензтэй вирусны программ хуваарилагдсан бөгөөд төвийн болон харьяа салбаруудын компьютеруудад хуваарийн дагуу суулгасан. Үлдсэн компьютерт нэмэлтээр вирусны лизентэй программ худалдан авч хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

### 4.10. *Мэдээллийн дэд сан, архивын ажлын талаар:*

Архив мэдээллийн дэд сангийн салбар нь 2024 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөг хийж УЦУОШТ-ийн даргаар батлуулан АМСХ-т дамжуулсан. УЦУОШТ-ийн харьяа салбаруудаас шинжилгээний баримтуудыг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэлээ. Хадгаламжийн сангийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэж байна.
АМСХ-с ирсэн 2023 оны ажлын дүн, хариу зааварчилгаа, 2024 онд хийх ажлын зөвлөмжийг хүлээн авч, УЦУОШТ-ийн даргад танилцуулан мөрдөн ажилласан. УЦУОШТ-с АМДС-нд баримт цахимжуулах ажилд скайнер, ЦД-1 дэвтрийг хавтаслах зориулалтын хавтсаар хангасан.



*Зураг. Төрийн архивт баримт шилжүүлсэн хавтас, байгууллагаас олгогдсон скайнер*

**Мэдээллийн дэд сангийн ажлын талаар:** Цаг уурын салбараас горимын мэдээ ISX.TAB.RES хүлээн авч цахим сан үүсгэсэн. Ховд, Байтаг, Мөнххайрхан, Цэцэг, Дунд-Ус өртөөний AWS-310 автомат станцын мэдээ, Мөст, Манхан, Чандмань өртөөний AWS-330 автомат станцын мэдээ, Зэрэг өртөөний CAMS-620, Ховд өртөөний AWS-310R нарны автомат станцын мэдээг сар бүр хүлээн авч тасалдлыг уншуулан акт, протокол хөтлөн цаг хугацаанд нь дамжууллаа. /10,6 GB/

Баримт цахимжуулах ажлын хүрээнд: Ховд, Байтаг, Зэрэг өртөөний 1985-1987 оны нийт 9 жилийн 108 сарын 4441 хуудас баримтыг (ЦД-1 дэвтэр) скайнердаж, 4.00 GB хэмжээтэй цахим сан үүсгэн төвд дамжууллаа.


Б. ЦАХИМ МЭДЭЭ ХҮЛЭЭН АВСАН АКТ
Архив мэдээллийн сангийн хэлтэст
1985-1987 оны Байтаг, Зэрэг, Ховд өртөөний ЦД-1 дэвтэр цахимжуулсан
Ховд аймгийн Архив мэдээллийн дэд сан
НИЙТ ДҮН: Файлын тоо 4364 хэмжээ 3.99 /GB/

*Зураг. Бүртгэл үүсгэсэн байдал*

Харьяа 9 өртөөний термограф, гигрограф, барограф, плювиографын 2016-2023 оны

- 2016 - 7004 /4.14 gb/
- 2017 - 7036 /3.65 gb/
- 2018 - 7054 /2.44 gb/
- 2019 - 7035 /2.42 gb/
- 2020 - 6937 /2.64 gb/
- 2021 - 6953 /2.61 gb/
- 2022 - 6991 /13.8 gb/
- 2023 – 6941 /10.9 gb/

хэмжээтэй 9 салбарын 72 жил 864 сарын 55951ш лент скайнердаж цахим сан үүсгэн төвд дамжуулсан.

http://192.168.100.18/ cliwari/index.jsp хаягаар Cliwari-т хандан харьяа өртөөнүүдийн мэдээллийг авч мэдээлэл үйлчилгээний ажилдаа ашиглаж байна.

- Ховд аймгийн засаг даргын тамгын газарт цаг уурын өртөө харуулын температур, тунадасны мэдээ
- Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын засаг даргын тамгын газарт тус сумын 2021-2023 оны салхины дундаж, их хурд
- Дөргөн сумын засаг даргын тамгын газарт Чандмань, Дөргөн, Мянгад сумын 2020-2022 оны чийгийн үзүүлэлт, салхины хурд, усны өнгөрөлтын мэдээ
- Статистик хэмжил зүйн газарт сар бүрийн цаг агаарын элемент үзэгдлийн түүвэр, агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг хүхэрлэг хий- SO2, азотын давхар исэл -NO2, тоосонцор -PM2.5 зэрэг үзүүлэлтээр гаргаж өгч үйлчиллээ. 2024 онд мэдээллээр үйлчилж 100,000 төгрөгний орлого оруулсан. /УЦУОШТөв төрийн сан 100160013404 тоот дансаар/

**Архивын чиглэлээр:**Архив мэдээллийн дэд санд цаг уурын салбараас 16ш - ЦД-1 дэвтэр, 16ш - ЦД-5 дэвтэр, 1ш - ЦД-3 дэвтэр, өөрөө бичигчийн лент (6941ш) 26 ХН, нийт 59 ХН, ХАА-н салбараас 1329 хуудас 32 ХН, Ус судлалын салбараас 11ш - УД-1 дэвтэр, 10ш - УД-2 дэвтэр, 1ш - УД-3 дэвтэр, УХ-3 хүснэгт 1ш нийт 5150 хуудас 23 ХН, БОШЛ-с 387 хуудас 4 ХН, УМС-с 1025 хуудас 2 ХН баримт цаасан хэлбэрээр хүлээн авч 2023 оны нийт **120** хадгаламжийн нэгж үүсгэлээ.

ХАА , цаг уур , ус судлалын салбарын мэдээг цахим хэлбэрээр хүлээн авч цахим сан үүсгэлээ.

Архивын эрэл хайлтын ADRSS программд 2023 оны баримтаа шивж бүртгэсэн.

- Цаг уур, уур амьсгалын мэдээ баримтын хөмрөгт 2332 хадгаламжийн нэгжийн 452288 хуудас
- ХААЦУ-н шинжилгээний баримтын хөмрөгт 451 хадгаламжийн нэгжийн 23105 хуудас
- Ус судлалын баримтын хөмрөгт 754 хадгаламжийн нэгжийн 155364 хуудас
- Байгаль орчны шинжилгээний баримтын хөмрөгт 82 хадгаламжийн нэгжийн 4422 хуудас
- Нарны цацрагийн баримтын хөмрөгт 77 хадгаламжийн нэгжийн 35160 хуудас
- Цаг агаарын зураг мэдээний баримтын хөмрөгт 8 хадгаламжийн нэгжийн 3919 хуудас нийт **6** хөмрөгийн **674258 хуудас** бүхий **3704** хадгаламжийн нэгжийг шивж дамжууллаа.





Ховд аймгийн АМДС-д хүлээж авсан 2023 оны өөрөө бичигчийн лентний бүртгэл

| Лентний төрөл | Станцын тоо | Станцын нэр | Станцын индекс | Баримтын оны хязгаар | Лентний тоо | Дутуу лентний тоо | Нийт лентний тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| Термограф | 1 | Байтаг | 44265 | 2023.01-12 сар | 365 | | 3285 |
| | 2 | Зэрэг | 44264 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 3 | Манхан | 44361 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 4 | Мөст | 44267 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 5 | Мөнххайрхан | 44260 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 6 | Ховд | 44218 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 7 | Чандмань | 44269 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 8 | Цэцэг | 44271 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 9 | Дунд-Ус | 44364 | 2023.01-12 сар | 365 | | |
| Гигрограф | 1 | Байтаг | 44265 | 2023.01-12 сар | 365 | | 3285 |
| | 2 | Зэрэг | 44264 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 3 | Манхан | 44361 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 4 | Мөст | 44267 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 5 | Мөнххайрхан | 44260 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 6 | Ховд | 44218 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 7 | Чандмань | 44269 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 8 | Цэцэг | 44271 | 2023.01-12 сар | 365 | | |
| | 9 | Дунд-Ус | 44364 | 2023.01-12 сар | 365 | | |
| Барограф | 1 | Байтаг | 44265 | 2023.01-12 сар | 52 | | 371 |
| | 2 | Зэрэг | 44264 | 2023.01-12 сар | 53 | | |
| | 3 | Манхан | 44361 | 2023.01-12 сар | 52 | | |
| | 4 | Мөст | 44267 | 2023.01-12 сар | 53 | | |
| | 5 | Мөнххайрхан | 44260 | 2023.01-12 сар | 53 | | |
| | 6 | Ховд | 44218 | 2023.01-12 сар | 52 | | |
| | 7 | Чандмань | 44269 | 2023.01-12 сар | 4 | | |
| | 8 | Цэцэг | 44271 | 2023.01-12 сар | багажгүй | | |
| | 9 | Дунд-Ус | 44364 | 2023.01-12 сар | 52 | | |
| плювиограф | 1 | Ховд | 44218 | 2023.05-09 сар | багажгүй | | |
| | | Дүн | | | 6941 | | 6941 |

*Зураг. Уур амьсгалын мэдээллийн сангийн удирдлагын систем /CliWare-2.1/-г ашиглаж мэдээ мэдээллээр үйлчилсэ,цаг уурын өртөөдөөс авсан өөрөө бичигч лент скайнердсан бүртгэл*

Ховд, Байтаг, Зэрэг өртөөний 1985-1987 оны баримтыг төрийн архивт шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Түүхчилсэн лавлах
- Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл
- Товчилсон үгийн жагсаалт
- Сэдэв зүйлийн заагч
- Ашигласан ном зүй
- Баталгааны хуудас зэрэг нийт 30 хуудас хөмрөгийн данс үйлдэж төрийн архивт баримт хүлээн авсан, шилжүүлсэн актын хамт АМСХ-т хүлээлгэн өгсөн. Ховд, Байтаг, Зэрэг өртөөний ЦД-1 дэвтрээр 9 ХН бүрдүүлж зориулалтын хавтсаар хавтасласан.





*Зураг. Хөмрөгийн данс ЦД-1 дэвтрийг хавтасласан*
*байдал баримт шилжүүлсэн* акт

Архивын үндсэн баримтын мэдээг МАЯГТ-1, үндсэн үйл ажиллагааны мэдээг МАЯГТ-2 хүснэгтийн дагуу гаргаж дамжуулсан.





*Зураг.Архивын үндсэн баримтын мэдээг маягтын дагуу гаргаж байталгаажуулсан байдал*

Архивын ерөнхий газарт хүргүүлэх шинжилгээ судалгааны мэдээ баримтын тоо хэмжээг загвар хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлсэн. Архивын баримтын нэгдсэн тооллого хийж 674258 хуудас 3704 хадгаламжийн нэгжийн тооллого хийн бүртгэлийг АМСХ-т дамжуулсан. БНШК-ын хурлыг хийж протоколыг төвд дамжуулсан.

**4.11. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны талаар:**

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 96-р тогтоолоор батлагдсан “Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Ховд аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх, бэлчээрийн ургамлын ургалтыг дэмжиж зуншлагын байдалд таатай нөлөө үзүүлэх, аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, ган цөлжилтэд нэрвэгдэж байгаа бүс нутгийн байгаль орчны төлөв байдлыг дэмжих зорилгоор Ховд аймгийн УЦУОШТ-ийн дэргэдэх “Ховд-Бороо”-1, “Ховд-Бороо”-2 экспедицүүд ЦУОШГ-ын даргын 2024 оны 05-р сарын 22-ны өдрийн А/123 тоот тушаалын оны 05 дугаар сарын 22-нээс 09 дүгээр сарын 15-ны хооронд Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсэг болон Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор, Өндөр уулын бүс нутгаар тус тус цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг амжилттай явуулсан.







*Зураг. Газрын даргын тушаал, төвийн даргын экспедицид ажиллах бүрэлдэхүүний тушаал*

Тус төвийн “Ховд-Бороо-1” экспедицийн бие бүрэлдэхүүнд Баруун бүсийн экспедицийн дарга А.Энхзаяа, ЦАЗНөлөөлөх үйлчилгээний зэвсэг хариуцсан ХХАА-ны ерөнхий инженер Б.Отгонтөмөр, ЦАЗНөлөөлөх судалгаа, радар хариуцсан ерөнхий инженер П.Мягмардорж, “Ховд-Бороо-2” экспедицийн бие бүрэлдэхүүнд экспедицийн дарга, Цаг агаарт зориудаар нөлөөлөхийн инженер Д.Төрмөнх, Синоптик инженер М.Баярмаа, Техникч, жолооч С.Нямхүү нар ажилласан.

2024 оны 4 дүгээр сард Ховд аймгийн хэмжээнд хөрсний гадарга дээр хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 36-49 градус дулаан, хүчтэй салхи шуурга ихтэй, хуурайшилт ихтэй байсан учраас 5 дугаар сарын 8-нд Баян-Өлгий аймгийн Толбо сумын Хашаатын хөтөл гэдэг газар “Ноцоох зуух” ажиллуулж 2ш түлш шатааж ажилласан. Үүний үр дүнд Их нууруудын хотгор болон Өндөр уулын бүс нутгаар 0.0-9.4 мм хур тунадас орсон. Бэлчээрийн ургамлын ургалтанд таатай нөлөө үзүүлж ажилласан.

Ховд-Бороо-1, 2 экспедиц нь ЦУОШГазрын даргын **2024 оны 05 дугаар сарын 22-ний А/123 тоот** тушаалаар 2024 оны 05 дугаар сарын 22-нээс 09 дүгээр сарын 15 хүртэл цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 2 экспедиц нийт 18 удаагийн давхардсан тоогоор 27 удаа ЦАЗНөлөөлж, өдрүүдийн газар, орчин, 850, 700, 500, 300мбар гадаргын өндрийн зураг, Рединг, Вашингтоны төвүүдийн тоон прогнозын үр дүнгүүд, ММ5, Япон, Орос, КМА-гийн даралтын орон, салхи, тунадасны прогноз зургууд, FY-2D, Солонгосын хиймэл дагуулын үүлний зургуудыг ашиглан дүн шинжилгээ хийж үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэн Ховд аймгийн нутаг дэвсгэрийн зуншлагын байдалд таатай нөлөө үзүүлж ажилласан болно. Экспедицүүд ЦАЗН-х үйл ажиллагаанд гарсан өдөр бүрийн үр дүнг тооцож,



зураглал үүлдэж эдийн засгийн үр ашигийн тооцоо гаргаж ажиллаж байна.

**Жишээ нь:** 2023 онд пуужингийн нөөц бага байсан учраас гаралтын тоо бусад онуудыг бодоход харьцангуй цөөн байсан ба тиймээс 2024 он гараад Алтайн өвөр говь болон өндөр уулын бүс нутгаар цас ихтэй байсан ч 3-4 сард салхи, шуургатай өдрүүд ихтэй байсан ч хавар эртдээ ургамлын цухуйлт эхэлж хур тунадас орохгүй байсан ЦУОШГ-ын даргын зөвшөөрлөөр RYG-1 ноцоох зуухыг Эрдэнэбүрэн сумын Хашаатын хөтөл гэдэг газар 2ш түлш шатааж ажиллуулсан.

**1. 2024 оны 06 сарын 12–ны үйл ажиллагаа**

| № | 1. | 2. |
|---|---|---|
| Харвалт үйлдсэн огноо | 2024.06.12 | 2024.06.12 |
| Хугацаа /цаг, мин/ | 13 цаг 49 минут | 15 цаг 20 минут |
| Засаг захиргааны харъяалал | Ховд аймаг Эрдэнэбүрэн сум Шураг баг | Ховд аймаг Ховд сум Баянбулаг баг |
| Газрын оноосон нэр | Адаг үзүүр | Ишгэн толгой |
| Газарзүйн солбилцол | 47$^0$17’53.5, 091$^0$19’26.5 Өндөр=1520м | 48$^0$09’13.9, 091$^0$36’41.5 Өндөр=1416м |
| Харвалтын төрөл | Угтаж | |
| Харвалтын өмнөх цаг агаарын төлөв байдал: $T_a$ /$^0$C/ | 21.9$^0$c | 21.8$^0$c |
| $T_x$ /$^0$C/ | | |
| F /%/ | 55% | 60% |
| P /гПа/ | 823.0 гПа | 822.9 гПа |
| dd /гра/ | 360 /Х/ | 045 /ЗХ/ |
| V /м/с/ | 6 м/с | 6 м/с |
| Үзэгдэл | Бороо | Бороо |
| Үүлний хэлбэр, хэмжээ | Ns, 10 балл | Ns, 10 балл |
| Үүлний үүсэл | Хүйтэн | |
| Газар орчмын даралтын орны байдал | Их даралтын орны өмнө | |
| 700 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл | Сул хотос, баруун баруун өмнөөс | |
| 500 гПа гадарга дээрх геопот орны байдал, урсгалын чиглэл | Сул хотос, баруун баруун өмнөөс | |
| Харвалт үйлдсэний дараах өөрчлөлт | Хур тунадасны эрчимшил нэмэгдсэн | |
| Хамарсан газар нутаг, тунадасны хэмжээ | Жаргалант – 0.0, Чандмань – 9.0, Мөст – 3.0, Дарви – 0.4, Мянгад – 5.0, Эрдэнэбүрэн -4.1, Дөргөн – 5.0 мм хур тунадас орсон. | |

Энэ өдрийн үйл ажиллагаанд экспедицийн бие бүрэлдэхүүнд Ховд-Бороо-1 экспедицийн дарга А.Энхзаяа, ЦАЗНөлөөлөх үйл ажиллагааны ерөнхий инженер Б.Отгонтөмөр, Синоптик инженер М.Баярмаа, ЦАЗНөлөөлөх судалгаа, радар хариуцсан ерөнхий инженер П.Мягмардорж нар ажилласан.



*2024 оны 06 дугаар сарын 12-ны зурагнууд өндрийн 850, 500, орчны зураг*

***Өртөө, харуулуудын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн08, 20 цагийн тунадасны хэмжээ:***

| № | Сумуудын нэрс | Хэмжээ /мм/ |
|---|---|---|
| 1 | Жаргалант | 0.0 |
| 2 | Чандмань | 9.0 |
| 3 | Мөст | 3.0 |
| 4 | Эрдэнэбүрэн | 4.1 |
| 5 | Дарви | 0.4 |
| 6 | Мянгад | 5.0 |
| 7 | Дөргөн | 5.0 |






## ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ТООЦОО:

Ховд-бороо-1 экспедиц нь 2024 оны 06 дугаар сарын 12-ны өглөө гарч аймгийн төвөөс 60 км-т Эрдэнэбүрэн сумын төвөөс баруун зүгт 30 км-т Шураг багийн Адаг үзүүр хэмээх

газарт 13 цаг 49 минут, 15 цаг 20 минутанд Ns хэлбэрийн 10 баллын үүлэнд нийт 2 ширхэг пуужин харваж ажилласан. Эрдэнэбүрэн, Мянгад, Дөргөн, Чандмань, Мөст, Дарви, Жаргалант сумын нутгаар 0.0 – 9.0 мм хур тунадас орсон. Эрдэнэбүрэн, Мянгад, Дөргөн, Чандмань, Жаргалант, Буянт сумын нутаг дэвсгэрт нийт 20003000$м^3$ талбайд /2.5 мм/ хур тунадас зориудаар нэмэгдүүлж 1000.150 сая төгрөгийн 50.007 сая тонн хурын усыг зориудаар нэмэгдүүлсэн байна.

2023-2024 оны өвөл манай аймгийн говийн бүс нутгаар угтвар чийг их, өвөл, хавартаа цас ихтэй байсан ба хээрийн бүс нутгаар угтвар чийгшил ихтэй байсан ч 04, 05 дугаар сард хур тунадас багатай байснаас хуурайшилттай, аэросиноптикийн тохиромжтой нөхцөл бүрдэлт муу үүлний масс нийт нутгийг хамрахгүй, тасанг, услаг багатай хэт өндөр, гол төлөв давхраат бөөн /Sc/. үүл, босоо хөгжлийн тасанг /Cb, Cu/ үүл орж ирж байгаа нь цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй байсан хэдий ч орон нутгийн чанартай үүлэнд нөлөөлж байсан.

“Ховд-Бороо”-2 экспедиц нь Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсэг болон Алтай өвөр говьд хур тунадас нэмэгдүүлэх ажлыг сүүлийн 4 жилийн хугацаанд амжилттай явуулж байна. 2023 онтой харьцуулахад Алтайн өвөр говиор аэросиноптикийн тохиромжтой нөхцөл бүрдэлт муу, үүлний масс нийт нутгийг хамарахгүй, услаг багатай гол төлөв давхраат бөөн /Sc/ үүл, босоо хөгжлийн тасанг /Cb, Cu/ үүл орж ирж байгаа нь цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй байсан. Алтайн өвөр говьд 5 удаагийн гаралтаар 8ш пуужин харваж хур тунадасны хэмжээг 50-55 хувиар нэмэгдүүлсэн байна.
/Дэлгэрэнгүй тайланг ЦУОШГ-н Хурын шимийн салбарт хүргүүлсэн/

### 4.12. Шалган туслах ажлын талаар

Төвийн харъяа нэгжүүдийн бүх төрлийн шинжилгээний хөтөлбөрт ажлын хэвийн тасралтгүй байдлыг хангуулах үүднээс шалган туслах ажлыг энэ онд цаг уурын өртөө, харуул, ус судлалын харуулуудад давхардсан тоогоор 1-2 удаа шалган туслах ажлыг төвийн салбар хариуцсан технологич инженерүүд, хэлтсийн дарга нар салбаруудад ажиллахдаа бүх төрлийн шинжилгээний хөтөлбөрт ажлын явц, ажилд гарч байгаа үл тохиролд аргазүйн заавар зөвөлгөө өгөх, бүх багаж тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ хийх, шалгаж тохируулах, харьцуулсан тоололт авах, тухайн өртөө харуулуудын албан хаагчдад хичээл сургалт явуулах, ажиллах орчин нөхцөл, шаардлагатай байгаа багаж төхөөрөмж, цэвэрлэгээний материал, бичиг хэргийн материал гэх мэтээр хангаж, техникчдын мэргэжлийн мэдлэг шалгах шалгалт, акт зааварчилгаа бичиж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа. Шалгалтаар шинжилгээний бүх багаж тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн байлаа. Цаг уурын 9 өртөө, ХАА-н 7 харуул, Ус судлалын 11 харуулд салбар хариуцсан инженер, техникчид ажилласны дээр Мөстөл судлалын Цамбагарав уулын автомат станцын мэдээлэл, цэвдэг судлалын Цэцэг, Буянт сумын 2 цэгийн автомат багажуудаас тоололт авч ажилласан. Ус судлалын 11 харуулууд шалган туслах ажил хийж, хөдөлсөн шонгийн засвар дахин гаргаж өгсөн. Мөнххайрхан өртөөнд болсон туршлага судлах сургалтаар цаг уурын өртөө харуулуудад автомат станцын үзлэг тохиргоо хийх талаар автомат станц дээр үзүүлж тохиргоо хийж дадлага сургалт, бэлчээрийн хашаалсан талбайд хийгддэг ургамлын үзэгдэл зүйн ажиглалтаар үзүүлэн ажиглалт, Дунд-цэнхэр ус судлалын харуулын цэг дээр усны өнгөрөлтөөр үзүүлэн ажиглалт хийж, салбаруудын техникчдын асуусан эргэлзээтэй зүйлийг харилцан ярилцсан үр дүнтэй ажил болсон.











*лган туслах ажлаар ажиллаж байгаа нь*

**ЗУРГАА. УЦУОШТ-ИЙН 2024 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ДҮГНЭЛТ:**

1.Тус төв нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 77 төрлийн ажил төлөвлөн ажилласан бөгөөд тус ажил 99.15%-тай биелэгдсэн.

2.Ажилчдын тав тухтай ажиллах нөхцөл бүрдүүлэх үүднээс аймаг, сум орон нутгийн хөгжлийн сангаас салбар нэгжүүд нийт 53.5 сая төгрөгний санхүү сум орон нутгаас шийдүүлж, ажилчдын ажиллах тав тухтай орчин бүрдүүлэх, шинжилгээний хөтөлбөрт ажил хийхэд шаардлагатай багаж төхөөрөмжийг шийдүүлэн ажиллсан. Төвийн халаалтыг аймгийн төвийн төвлөрсөн дулаанд холбосон. /85 сая/

3.Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс 2023 онд хийсэн ажлыг хэлэлцэж бусдыгаа хошуучлан ажилласан 52 хүнд үндсэн цалингийн 10-25%-р 3 сарын хугацаатай ур чадварын нэмэгдэл олгосон.

3.Ажилчдын улиралд хийсэн ажлын үр дүнг хэлэлцэж /1,2-р улиралд/ үр дүнгээр 20-100% хүртэл 1 удаа 65 сая төгрөг, 3,4-р улиралд хийсэн ажлын үр дүнгээр 20-70% хүртэл 1 удаа 58 сая төгрөгний үр дүнг 96 албан хаагчид олгож ажилласан.

4. Бүх төрлийн шинжилгээний хөтөлбөрт ажил ямар нэгэн багаж тоног төхөөрөмжийн гэмтэл, саатлаас шалтгаалан тасарсан хөтөлбөрт ажил байхгүй, гарсан гэмтэлийг тухай бүр илрүүлэн засаж ажилласнаар хөтөлбөрт ажил бүрэн хийгдсэн.

5. Дээд газар болон аймаг орон нутгаас зохион байгуулсан олон нийтийн ажил болон сургалт мэдээлэлд албан хаагчдынхаа мэдлэг боловсрол, мэдээллийг нэмэгдүүлхэд анхаарч бүрэн оролцуулсан.

6. Дээд газар болон салбарын Яамнаас шийдэж, эрх шилжүүлэн өгсөн худалдан авах ажиллагааг хугацаанд нь амжилттай зохион байгуулсан.

7. Олон улсын төсөл хөтөлбөрт хамтран ажиллах саналаа хүргүүлснээр шинжилгээ,судалгааны хөтөлбөрт ажилд хэрэгтэй 9 нэр төрлийн /майхан мишок, гар чийдэн, зай батарей, халуун сав, хийлдэг гудас, powerbank, автомашин гм/ 237 сая 135 мянга,800 төгрөгний өртөгтэй багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг шийдвэрлүүлсэн.

8. ЦАЗН үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад гаралтын тоог нэмэгдүүлхэд аймгаас 10 сая төгрөгний дэмжлэг авсан.

9. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг 17 суманд зохион байгуулхад 3,8 сая төгрөгийг аймгаас шийдүүлж, тооллогын ажлыг хийж, тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

**ДОЛОО. ЦУОШГ-Т ТАВИХ САНАЛ ХҮСЭЛТ:**

1. Ажилчдын 5 жил тутмын нэмэгдэл олгуулах
2. Хээрийн хэмжилтэд олуулаа явах боломжтой Пургон Авто машин шийдэж өгөх
3. Шинжилгээ судалгаанд шаардлагатай байгаа зарим багаж тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах

/БТБ-ын ажиглалтанд цүнхтэй багаж/

4. Төвийн конторын барилгын дотоод дулааны шугам сүлжээг шинэчлэх 29 сая төгрөгийг шийдэж өгөх

5. Салбарын албан хаагчдыг тусгай хэрэгцээний нормын хувцасаар хангах

ТАЙЛАН БИЧСЭН:
УЦУОШТ-ИЙН ДАРГА А.ЭНХЗАЯА